



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 04. 30 № 3F-1/51
танай —-ны № —-т

Г Тайлан хүргүүлэх тухай Г

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэний дагуу аудитын тайлангийн хамт хүргүүлж байна.

Хавсралт 68 хуудастай.



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

• 000254000438

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“11.ХЭЛЭЛЦСЭН нь: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хэлэлцээд аудитын тайлангийн хамт Улсын Их Хуралд хүргүүлэхээр тогтов.” гэжээ.



ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлангийн талаар

Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг баталсан. Уг стратегийн баримт бичигт дунд хугацаанд өрийн удирдлагын чиглэлээр баримтлах дараах үндсэн 6 зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон Засгийн газрын өрийн багцын зорилтот бүтцийн хувьд 4 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг тодорхойлсон. Үүнд:

1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна;
2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна;
3. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ;
4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна;
5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана;
6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна болно.

Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт “Засгийн газар стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гурван жилд нэг удаа төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийн хамтаар дараагийн стратегийн баримт бичгийн төсөл өргөн мэдүүлэх хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, тайлагнана.” гэж заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн тайланг Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн хамт тайлагнаж байна.

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд буюу 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын нийт гадаад өрийн хэмжээ 37.1 тэрбум ам.доллар буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 157 хувьтай, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн хэмжээ 33.4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 41.8 хувьтай тус тус тэнцэж байна.

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг баталж, хэрэгжүүлснээр Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 8 жилийн хугацаанд 51.3 хувиар буурсан, хүүгийн төлбөрийн төсвийн зарлагад эзлэх хэмжээ 8 жилийн хугацаанд 9.6 хувиар буурсан зэрэг үр дүнтэй байлаа. Мөн Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Эс энд Пи, Фитч, Мүүдис зэрэг агентлагууд Монгол улсын зээлжих зэрэглэлийг 2024 онд нэмэгдүүлж, В+, В2 түвшинд хүргэсний

нэг шалтгаан нь Засгийн газрын өрийн оновчтой удирдлага, өрийн дарамт буурч байгаатай холбоотой болохыг онцолсон.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт туссан дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн болно. Үүнд:

Зорилт 1: Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хүсэлт ирүүлсэн ч Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлага хангагүй төслүүдийг буцаасан бөгөөд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилт”, “Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл”, “Улаанбаатар-Дарханы чиглэлийн зам барих төслийн нэмэлт санхүүжилт” зэрэг бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслүүдийн гадаад зээлийн хэлэлцээрийг байгуулсан.

Зорилт 2: Засгийн газрын гадаад үнэт цаасны хувьд Сенчири-2, Сенчири-3, Сенчири-4 зэрэг нийт 1.5 тэрбум ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төлбөрийн тэнцэлд ирэх гадаад төлбөрийн дарамтыг бууруулснаас гадна арилжааны нөхцөлтэй бондын үлдэгдлийг 2.5 тэрбум ам.доллар болгож 238 сая ам.доллароор бууруулсан. Засгийн газрын өрийн дарамтыг бууруулсан, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд сайжирсны үр дүнд Фитч, Эс энд Pi, Мүүдис агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B+, B2 болгон нэмэгдүүлсэн.

Зорилт 3: Засгийн газрын зээлийн төлбөрийг Монгол Улсад буцалтгүй тусlamж хэлбэрээр эрүүл мэндийн салбарын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх өр хөрвүүлэх хэлэлцээрийг Германы KfW банк болон Глобаль сантай байгуулсан.

Зорилт 4: Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг эхлүүлэх зорилгоор bonds.mse.mn системийг Монголын хөрөнгийн биржтэй хамтран хөгжүүлж, арилжааны бэлэн байдлыг хангаж, хөрөнгө оруулагчидтай тогтмол уулзалтыг зохион байгуулсан. Ингэснээр зах зээлийн хөгжлийг дэмжиж, хөрөнгийн зах зээлд төгрөгийн суурь хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор 2025 оны 04 дүгээр сараас эхлэн үнэт цаасны арилжааг эхлүүлсэн болно.

Зорилт 5: Засгийн газраас эдийн засгийн болон нийгмийн өндөр үр өгөөжтэй төслүүд болох “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл” болон “Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл”-ийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын өрийн баталгаа гаргасан.

Зорилт 6: Засгийн газрын өрийн товхимлыг цахим хуудсаараа дамжуулж улирал тутам тогтмол олон нийтэд ил тод байршуулж байна.

Стратегийн баримт бичигт туссан Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтцийн хүрээнд З үзүүлэлт болох хүүгийн зардлын үзүүлэлт, дахин санхүүжилтийн эрсдэлийн үзүүлэлт, хүүгийн эрсдэлийн үзүүлэлтүүд зорилтот түвшнийг хангаж байгаа бөгөөд ханшийн эрсдэлийн үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй болно. Энэ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдал 2022-2024 оны гүйцэтгэлээр төлөвлөсөн хэмжээнээс бага гарч дотоод өр нэмэгдүүлэх шаардлага багассан, мөн Засгийн газраас бага хүйтэй, урт хугацаатай гадаад зээлийн санхүүжилтээр төсөл, хөтөлбөр санхүүжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Үндэсний аудитын газраас стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хийсэн аудитын тайлангаар стратегийн баримт бичигт тусгагдсан нийт 23 арга хэмжээнээс 18-г бүрэн хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн. Аудитын тайланд туссан голлох дүгнэлт, зөвлөмжийг дурдвал:

1. Нийслэлээс гаргасан үнэт цаасны эрсдэлийг тогтмол үнэлж эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулах, аймаг, нийслэлийн үнэт цаасны хэмжээг хязгаарлах;
2. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулах;
3. Дунд хугацаанд дэвшүүлж буй зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;
4. Өрийн удирдлагын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх;
5. Бэлтгэл ажил хангагдаагүй төслийн зээлийн хэлэлцээр хийхгүй байх;
6. Гадаад өрийн Засгийн газрын өрд эзлэх хувь зорилтот түвшинд хүрээгүй зэрэг болно.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2025 онд дуусах бөгөөд Сангийн яамны зүгээс аудитын тайланд туссан зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэн стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангахаар төлөвлөн ажиллаж байна.

---o0o---

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-
2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

1. Θмнөтгөл.....	3
2. Θрийн өнөөгийн нөхцөл байдал.....	4
3. Дунд хугацааны стратегийн зорилт, түүний хэрэгжилт	9
4. Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтэц, зардал эрсдэлийн шинжилгээ.....	21
5. Засгийн газрын зээллэгийн төлөвлөгөөний хэрэгжилт	23

1. ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр “Засгийн газрын өрийн зохицтой түвшнийг хангах, дунд хугацааны өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх, өр үүсгэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах” зорилготой Өрийн удирдлагын тухай хуулийг баталсан.

Өрийн удирдлагын тухай хуульд Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг бодлогын баримт бичгээр тодорхойлооор заасан ба тус хуулийн 13.1-д өрийн удирдлагын стратегийн зорилгыг “макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чиглэнэ” гэж тодорхойлсон байdag.

Өрийн удирдлагын тухай хуулийн 14.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн баримт бичгийг боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабрын дагуу батлуулна” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг баталсан.

Стратегийн баримт бичигт дунд хугацаанд өрийн удирдлагын чиглэлээр баримтлах үндсэн 6 зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ болон Засгийн газрын өрийн багцын зорилтот бүтцийн хувьд 4 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг тодорхойлсон. Үүнд дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад зээллэг хийхээс татгалзах, Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулах бэлтгэл ажлыг хангах, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг болон төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, Засгийн газрын өрийн баталгааг стратегийн томоохон төслүүдэд гаргах, өрийн ил тод байдлыг сайжруулах бодлогыг баримтлахаар заасан.

Сангийн яамны зүгээс Өрийн удирдлагын тухай хуулийн 15.1.2-т “Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гурван жилд нэг удаа гаргаж, энэ хуульд заасны дагуу Улсын Их Хуралд хүргүүлэх” гэж заасныг үндэслэн энэхүү тайланг боловсруулан тайлагнаж байна.

2. ӨРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1 Улсын нийт гадаад өр

Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.4-т “улсын нийт гадаад өр”-ийг Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүрэг гэж тодорхойлсон. Монголбанк болон Сангийн яам хамтран улсын нийт гадаад өрийг Олон улсын валютын сан /ОУВС/-ийн статистик боловсруулах б дугаар гарын авлагыг үндэслэн “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулж, энэ хүрээнд мэдээлэл түгээх ерөнхий шаардлагын дагуу 2010 оноос эхлэн олон нийтэд мэдээлж байна.

Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 37.1 тэрбум ам.доллар байгаагаас Засгийн газрын гадаад өр 7.9 тэрбум ам.доллар (21.2%), Төв банкны гадаад өр 1.1 тэрбум ам.доллар (2.9%), бусад салбаруудын өр 8.2 тэрбум ам.доллар буюу (22.2%), Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын өр 2.7 тэрбум ам.доллар буюу (7.2%) байгаа бол компани хоорондын зээллэг 17.3 тэрбум ам.доллар (46.5%)-ыг тус тус зээлж байна.

Хүснэгт № 1. Улсын нийт гадаад өрийн статистик, 2023-2024 онд /сая ам.доллар/

Салбарын ангилал	2023 он	2024 он
Засгийн газар	8,105.1	7,887.6
Төв банк	1,784.8	1,086.3
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,733.2	2,657.0
Бусад салбарууд	7,865.8	8,235.1
Компани хоорондын зээллэг, шууд хөрөнгө оруулалт	15,080.6	17,254.3
Нийт гадаад өр	34,569.5	37,117.3

Эх сурвалж: Монголбанк

2.1.1 Засгийн газрын гадаад өр

Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 7.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 217.5 сая ам.доллараар буюу 2.7 хувиар буурсан байна. Энэ нь гадаад үнэт цаасны үлдэгдлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж барагдуулсан, хугацаанаас нь өмнө буцаан худалдан авсантай холбоотой байна.

2.1.2 Төв банкны гадаад өр

Төв банкны өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 1.1 тэрбум ам.долларт хүрч 2023 оны үлдэгдлээс 639.5 сая ам.доллараар буюу 35.8 хувиар буурсан байна. Энэ нь БНХАУ-ын Ардны банктай хийсэн своп хэлцлийн үлдэгдлээс 6.0 тэрбум юанийн хэмжээтэй хэсгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

2.1.3 Хадгаламжийн байгууллагын гадаад өр

Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)-ын гадаад өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 2.7 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 923.8 сая ам.доллароор буюу 53.3 хувиар өсжээ. Энэ нь арилжааны банкнууд олон улсын зах зээлд үнэт цаас гаргах замаар эх үүсвэр төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

2.1.4 Бусад салбаруудын гадаад өр

Улсын нийт гадаад өрд эзлэх бусад салбарууд болон компани хоорондын зээллэгийн өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 25.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх 2023 оны түвшнээс 2,543.0 сая ам.доллароор буюу 11.1 хувиар өссөн байна.

2.2 Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 33,384.6 тэрбум төгрөг, ДНБ-д харьцуулсан харьцаа 41.8 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт № 2. Засгийн газрын өр, 2023-2024 он, тэрбум төгрөг

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2023 он	2024 он*
1. Засгийн газрын дотоод өр	234.1	400.5
1.1. Үнэт цаас	234.1	400.5
2. Засгийн газрын гадаад өр	30,274.6	30,247.8
2.1. Үнэт цаас	9,371.7	8,655.0
2.2. Зээл	20,902.9	21,592.7
3. Бусад өр төлбөр	264.8	2,736.4
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	29.5	178.0
3.2. Орон нутгийн өр	4.5	2,558.4
3.3. Концесс (“барих-шилжүүлэх”)**	230.9	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	30,773.5	33,384.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	26,582.9	
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар***	65.0% (ӨҮЦ)	60.0% (Нэрлэсэн)
Засгийн газрын өр /ДНБ	43.7%	41.8%
Засгийн газрын өр (ӨҮЦ) /ДНБ	37.7%	

*-Урьдчилсан гүйцэтгэл

**-Төр, хувийн хэвшилийн түншлэлийн тухай хууль хэрэгжисэж эхэлсэнтэй холбоотойгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дахь хэсэг хүчингүй болсон.


***-2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг онөөгийн үнэ цэнээр илэрхийлдэг байсныг нэрлэсэн үлдэгдэл болгож өөрчилсөн

Эх сурвалж: Сангийн яам

2.2.1 Дотоод үнэт цаас

Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд нээлттэй хэлбэрээр Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй, төлбөрийн үүргийг хуваарийн дагуу гүйцэтгэж байгаа бөгөөд 2016 онд 5.5 их наяд төгрөгт хүрч байсан дотоод үнэт цаасны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 400.5 тэрбум төгрөгт хүрээд байна.

График № 1. Дотоод үнэт цаас, тэрбум төгрөг /2016-2024/



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс 2024 оны 11 дүгээр сард Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын үнэт цаасыг Нийгмийн даатгалын санд арилжаалсан. Энэхүү үнэт цаасны нөхцөлийн хувьд 300 тэрбум төгрөгийн хэмжээтэй, 1-3 жилийн хугацаатай, 8.5-9.5 хувийн хүйтэй байна.

2.2.2 Гадаад үнэт цаас

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 2.5 тэрбум ам.доллар буюу 8,655.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 3. Гадаад үнэт цаас, тэрбум төгрөг /2024.12.31/

№	Гадаад үнэт цаас	Купон	Хугацаа	Эргэн төлөх огноо	Үлдэгдэл сая ам.доллар	Үлдэгдэл
1	Номад	5.125%	5.5 жил	2026.04.07	572.7	1,958.7
2	Сенчири-1 2027 ¹	3.500%	6 жил	2027.07.07	420.1	1,436.8
3	Сенчири-1 2031 ¹	4.450%	10 жил	2031.07.07	510.7	1,746.7
4	Сенчири-2	8.650%	5 жил	2028.01.19	675.1	2,309.2
5	Сенчири-3	7.875%	5.5 жил	2029.06.05	351.9	1,203.6
НИЙТ					2,530.5	8,655.0

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор олон улсын зах зээлд 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 650.0 сая ам.долларын 8.65 хувийн хүйтэй “Сенчири-2” бондыг арилжаалж 2023 онд төлөгдөх “Гэрэгэ” бонд, 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын

тодорхой хэсгийг, мөн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 350.0 сая ам.долларын 7.875 хувийн хүйтэй “Сенчири-3” бондыг арилжаалж 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын тодорхой хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд тус тус шийдвэрлэсэн.

Түүнчлэн, стратегийн хэрэгжилтийн хугацаанд “Гэрэгэ” бондын үлдэгдэл 90.8 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр, “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр болох 52.9 сая ам.долларын төлбөрийг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр тус тус төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээс төлж барагдуулсан.

2.2.3 Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж, олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс зээл авч ашиглаж ирсэн бөгөөд нийт гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6,313.2 сая ам.доллар буюу 21,592.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 4. Гадаад зээлийн ашиглалт, тэрбум төгрөг /2023-2024/

Төрөл	2023 он		2024 он		НИЙТ	
	тб төгрөг	сая ам.доллар	тб төгрөг	сая ам.доллар	тб төгрөг	сая ам.доллар
Хөтөлбөрийн зээл	692.5	200.0	341.8	100.0	1,034.3	300.0
Төслийн зээл	1,214.2	361.6	2,041.7	603.1	3,255.9	964.7
НИЙТ	1,906.7	561.6	2,383.5	703.1	4,290.2	1,264.7

Эх сурвалж: Сангийн яам

Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 102 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд нийт 4,290.2 тэрбум төгрөгийг авч ашигласнаас 1,034.3 тэрбум төгрөг нь хөтөлбөрийн зээл зориулалтаар авч ашигласан байна. Харин төслийн зээлийн зориулалтаар 3,255.9 тэрбум төгрөгийг ашигласан болно.

Хүснэгт № 5. Гадаад зээлийн төлбөр, тэрбум.төгрөг /2023-2024/

Төрөл	2023 он		2024 он		НИЙТ	
	тб төгрөг	сая ам.доллар	тб төгрөг	сая ам.доллар	тб төгрөг	сая ам.доллар
Үндсэн төлбөр	959.8	275.5	1,232.9	363.8	2,192.7	639.3
Хүүгийн төлбөр	455.5	132.4	558.4	164.9	1,013.9	297.3
НИЙТ	1,415.3	407.9	1,791.3	528.7	3,206.6	936.6

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 2023-2024 онд буюу Стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаанд гадаад зээлийн төлбөрт нийт 3,206.6 тэрбум төгрөгийг төлж, үүнээс үндсэн төлбөрт 2,192.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1,013.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

2.2.4 Засгийн газрын өрийн баталгаа

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 178.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны БНХАУ-ын Хөгжлийн банкаас авч ашигласан “Чойбалсан ДЦС /дулааны цахилгаан станц/-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд шаардагдах 420.0 сая юанийн зээлд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр гаргасан Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл болно.

Түүнчлэн, Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.1-т заасны дагуу Нийслэлээс олон улсын зах зээлд гаргасан 500 сая ам.долларын үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан болно.

Хүснэгт № 6. Засгийн газрын өрийн баталгаа /2024.12.31/

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	Нэрлэсэн үлдэгдэл	
				Үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг
1	Монгол Улсын Хөгжлийн банк	Хятадын хөгжлийн банк	Юань	379.9	178.0
2	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Олон улсын хөрөнгө оруулагчид	Ам.доллар	500.0	1,725.1
НИЙТ				1,903.1	

Эх сурвалж: Сангийн яам

2.2.5 Орон нутгийн өр

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил төслийдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад зориулж гаргаад байна. Ингэснээр орон нутгийн өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2,558.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 7. Орон нутгийн өр /2024.12.31/

№	Үнэт цаас гаргагч	Зориулалт	Гаргасан огноо	Эргэн төлөх огноо	Нэрлэсэн үлдэгдэл	
					Тэрбум төгрөг	
1		Зам засвар, арчилгаа	2024.06.25	2025.06.25		106.2
2		Зам засвар, арчилгаа	2024.06.25	2026.06.25		106.8
3	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Бөөрөлжүүтийн ДЦС барих	2024.06.25	2027.06.25		321.9
4		Батарей хуримтлуурын станц барих	2024.12.26	2029.12.26		298.4
5		Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах	2024.11.29	2027.08.29		1,725.1

НИЙТ				2,558.4
------	--	--	--	---------

Эх сурвалж: Сангийн яам

3. ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийт 6 зорилт, тэдгээр зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 23 арга хэмжээг тодорхойлсон бөгөөд эдгээр арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна.

Зорилт 1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

1.1 Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөжс, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглаас татгалзах;

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг сайжруулах, төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулах арга хэмжээний хүрээнд салбарын яамд болон Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн, гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих 15 төслийн хүсэлтийг холбогдох тайлбаруудын хамт буцаасан болно.

Эдгээр төслүүдийн зээлийн хүсэлт нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5-д заасан шаардлагууд болох төслийн техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн бодлогын баримт бичигт тусаагүй зэрэг шаардлагуудыг хангаагүй байсан болно.

1.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжсүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;

Засгийн газраас стратегийн хэрэгжилтийн хугацаанд нийт 4,290.2 тэрбум төгрөгийн гадаад зээлийн хөрөнгийг авч ашигласнаас 3,255.9 тэрбум төгрөгийг төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зорилгоор, үлдсэн 1,034.3 тэрбум төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрийг төсвийн дэмжлэг, төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор авч ашигласан.

Энэхүү Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтыг эдийн засгийн салбараар авч үзвэл орон сууц, нийтийн аж ахуйн салбарт 37.6 хувийг, аж үйлдвэрийн салбарт 17.8 хувийг, зам, тээврийн салбарт 13.2 хувийг, эрчим хүчний салбарт 11.1 хувийг, эрүүл мэндийн салбарт 6.6 хувийг, үлдсэн 13.7 хувийг бусад салбарт авч ашигласан байна.

Түүнчлэн, стратегийн тайлант хугацаанд Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан 18 төслийн хүрээнд нийт 1,126.8 сая ам.долларын гэрээг олон улсын санхүүгийн байгууллагууд болон хоёр талт түнш орнуудтай байгуулаад байна.

1.3 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг хийхгүй байх;

Засгийн газраас стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй байна.

Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2.1 Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, Засгийн газрын гадаад үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлэх,

Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан бондуудын хоёрдогч зах зээл дэх үнэ, өгөөжийн судалгааг тогтмол хийж тухайн бондуудын үнэ анх гаргасан үнээс бага болж, буцаан худалдан авах хэмжээ хуваарыт хугацаанд төлөх хэмжээнээс бага болсон “ценх” үед буцаан худалдан авах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Тухайлбал, 2023 онд “Номад” бондын нийт 22.0 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг, 2024 онд “Номад”, “Сенчири-1” бондуудын нийт 98.9 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг зах зээлийн үнээс доогуур үнээр буцаан худалдан авсан болно.

2.2 Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримталаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири-2” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалж “Гэрэгэ” бондын төлбөрөөс 435.2 сая ам.долларыг, “Хуралдай” бондын төлбөрөөс 209.3 сая ам.долларыг дахин санхүүжүүлсэн, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Сенчири-3” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалж “Хуралдай” бондын төлбөрөөс 339.7 сая ам.долларыг дахин санхүүжүүлсэн.

Ингэснээр 2023-2024 оны хооронд нийт 1.4 тэрбум ам.долларыг төлөх хуваарытай байсныг төсөв, төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөцтэй уялдуулан боломжит хэмжээгээр төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулах, үлдсэн хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд шийдвэрлээд байна.

Түүнчлэн, Засгийн газар олон улсын санхүүгийн зах зээлд 500 сая ам.долларын хэмжээтэй, 6.625 хувийн хүүтэй Сенчири-4 үнэт цаасыг зах зээлийн тогтвортгүй байдал, АНУ-ын гадаад худалдааны бодлого, БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр арилжаалсан. Энэхүү өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд “Номад” бондын төлбөрөөс 391.7 сая ам.долларыг, “Сенчири-2” бондын төлбөрөөс 108.3 сая ам.долларыг тус тус дахин санхүүжүүлсэн.

2.3 Дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх;

Засгийн газрын зүгээс арилжааны нөхцөлтэй гадаад өрийн хэмжээг бууруулах, арилжааны нөхцөлтэй зээллэгийн төсөв болон төлбөрийн тэнцэлд ирэх төлбөрийн дарамтыг бууруулах бодлогыг баримталж, 2017 оноос хойш өрийн зохицуулалт, дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалаагүй байна. Үүний үр дүнд Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2017 онд 3.1 тэрбум ам.доллар байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 2.5 тэрбум ам.долларт хүрч буурсан.

2.4. Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах

Улсын зээлжих зэрэглэл нь тухайн улсын хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх гол шалгуур үзүүлэлт бөгөөд гадаад, дотоод хөрөнгө оруулагчдаас тухайн улсад оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээлийн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм.

Засгийн газраас сүүлийн жилүүдэд зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдад Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлын талаарх мэдээг тухай бүр хүргэн, олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ тухай бүр хариуцлагатайгаар хүлээж, Засгийн газрын гадаад үнэт цаасны эргэн төлбөрүүдийг цаг хугацаанд нь эргэн төлж ажилласнаар олон улсын санхүүгийн зах зээл дээрх нэр хүнд, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдалгүй ажиллаж байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2024 онд Фитч агентлагаас “B+, тогтвортой”, Эс энд Pi агентлагаас “B+, ээрэг”, Мүүдиз агентлагаас “B2, тогтвортой” төлөвтэй болгож ахиулсан. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоолгох ажлын хүрээнд Эс энд Pi, Фитч, Мүүдиз агентлагуудад Монгол Улсын төсөв, санхүү, макро эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвийн талаарх мэдээллийг тус байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу хагас жил бүр тогтмол хүргүүлдэг бөгөөд жилд нэг удаагийн уулзалтыг зохион байгуулж зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийлгэдэг болно.

Зээлжих зэрэглэл тогтоолгох зорилгоор зохион байгуулсан арга хэмжээ:

1. Эс энд Pi агентлаг нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн 2024 оны үнэлгээг хийхтэй холбоотойгоор 2024 оны 08 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд Монгол Улсад ирж, холбогдох төрийн болон олон улсын байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй уулзалт хийж ажилласан.
2. Фитч агентлаг нь 2024 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг 2 удаа хийхээр мэдэгдсэн. Энэ хүрээнд эхний үнэлгээг 2024 оны 01 дүгээр сард цахим хурлаар зохион байгуулан үнэлж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B/тогтвортой” хэвээр хадгалж буйгаа 2024 оны 02 дугаар сарын 2-ны өдөр зарласан. Фитч агентлагийн 2024 оны 2 дахь үнэлгээг 2024 оны 09 дүгээр сарын 2-3-ны өдөр

Монгол Улсад ирж холбогдох байгууллагуудтай уулзаж, шинээр байгуулагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон макро эдийн засаг, төсөв санхүүгийн мэдээлэл авч ажилласан ба улмаар Монгол Улсын 2024 оны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “B+, тогтвортой” болгон сайжруулснаа 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр танилцуулсан.

3. Мүүдиз агентлагийн хувьд Монгол Улсын зээлжих зэрэглэл “B3”, төлөв “Тогтвортой” байгаа нөхцөлд 2 жилд нэг удаа зээлжих зэрэглэлийн шийдвэрийг гаргадаг. Харин Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын талаарх тайланг жилд 2 удаа нийтлэн ажиллаж байна. Энэ хүрээнд Мүүдиз агентлаг нь 2024 оны 02 дугаар сарын 12 болон 8 дугаар сарын 27-ны өдөр тус тус гаргасан ба ингэхдээ Монгол Улсын Засгийн газраас цахимаар мэдээлэл авч ажилласан.

Түүнчлэн, Засгийн газраас хөрөнгө оруулагчидтай тогтмол уулзалт зохион байгуулж, олон улсын зах зээлд үнэт цаас гаргах, санхүүжилт татах боломжийг үргэлж нээлттэй байлгах тал дээр анхаарч ажиллаж байна. Тухайлбал, 2023 онд гаргасан “Сенчири-2” болон “Сенчири-3” үнэт цаасны хүрээнд хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулж, Монгол Улсын эдийн засаг, улс төр, төсвийн мэдээллийг тогтмол өгч ажилласан бол 2023 оны 06 дугаар сар, 2024 оны 07 дугаар саруудад олон улсын хөрөнгө оруулагчидтай биетээр уулзаж мэдээлэл өгсөн. Мөн цахимаар тогтмол мэдээлэл хүргүүлдэг бөгөөд бусад хөрөнгө оруулагчдад зориулж Сангийн яамны цахим хуудсанд тогтмол Засгийн газрын өрийн мэдээллийг байршуулж байна. Түүнчлэн, дараах мэдээллийг Монгол Улсад байгаа хөрөнгө оруулагчдад хүргүүлж байна. Үүнд:

Хөрөнгө оруулагчдад зориулан зохион байгуулсан арга хэмжээ, өгсөн мэдээлэл:

1. Засгийн газрын гадаад хөрөнгө оруулагчдад тогтмол мэдээлэл хүргэн ажиллах хүрээнд Сити /Citi/ болон Дойче /Deutsche/ олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран “Хөрөнгө оруулагчдын уулзалт”-ыг Монгол Улсад 2024 оны 6-8 дугаар саруудад зохион байгуулсан. Хөрөнгө оруулагчдын уулзалтад нийт 15 хөрөнгө оруулагч хамрагдаж төрийн болон олон улсын байгууллагуудтай уулзаж Монгол Улсын эдийн засаг, төсөв санхүүгийн мэдээллийг авсан.
2. Сангийн яамны төлөөлөгчид Ж.П.Морган /J.P.Morgan/ олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас жил бүр зохион байгуулдаг “Хөгжиж буй зах зээлийн хөрөнгө оруулагчдын форум”-д 2024 оны 09 дүгээр сарын 16-19-ны өдрүүдэд Лондон хотноо оролцож 70 гаруй хөрөнгө оруулагчидтай уулзаж, Монгол Улсын эдийн засаг, цаашдын төлөв, Засгийн газрын бодлогын талаар мэдээлэл өгч ажилласан.

Засгийн газраас 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 500 сая ам.долларын хэмжээтэй, 6.625 хувийн хүүтэй үнэт цаасыг Сенчири-4 бондыг олон улсын зах зээлд арилжаалсан. Энэхүү үнэт цаасыг арилжаалах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 10-ны

өдрөөс 02 дугаар сарын 14-ний өдрийг дуустал рөүдшоу буюу олон улсад хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулж Монгол Улсын эдийн засаг болон төсвийн талаар мэдээллийг өгч ажилласан болно. Ингэхэд Ази, Америк, Европ, Ойрх Дорнодын нийт 133 хөрөнгө оруулагчид оролцсон байна.

Зорилт 3. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

3.1 Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанктай хамтран ажиллажс, гадаад өрийн үйлчилгээний хуваарийг валютын нөөцтэй уялдуулах, шаардлагатай тохиолдолд валют болон хүүгийн своп хэлэлцээрийг зээлдүүлэгч талтай хийх;

Засгийн газраас 2023-2024 оны хооронд гадаад өр төлбөрийг бууруулах, боломжит хэмжээгээр мөнгөн хөрөнгөөс төлөх, ингэхдээ Монгол Улсын гадаад валютын албан нөөцтэй уялдуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

1. Засгийн газрын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үнэ анх гаргасан үнээс бага байгаа үед буюу 2023 оны 10 дугаар сард “Номад” бондын төлбөрөөс 22 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг, 2024 оны 10-12 дугаар сард “Номад”, “Сенчири-1” бондуудын төлбөрөөс 98.9 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг тус тус буцаан худалдан авсан.
2. Засгийн газраас “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр болох 169.0 сая ам.долларыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр, “Гэрэгэ” бондын үлдэгдэл төлбөр болох 368.4 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр тус тус төлж барагдуулсан. Ингэснээр “Гэрэгэ”, “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр болох 143.7 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж, үлдсэн 483.7 сая ам.долларыг “Сенчири-2” болон “Сенчири-3” бондын хүрээнд өрийн зохицуулалт хийсэн болно.

3.2 Дэлхий нийтэд тулгараад байгаа инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөөгч хүү өсөх тохиолдолд тогтолцоог хүйтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах

Олон улсын эдийн засаг 2020 оноос хойш КОВИД-19 цар тахал, geopolитикийн мөргөлдөөн буюу ОХУ болон Украины хурцадмал байдал, Ойрх Дорнодод гарч буй мөргөлдөөн болон дэлхий нийтэд тулгараад буй инфляцын өсөлт зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж хөгжингүй орнууд бодлогын хүүгийн түвшнээ өсгөж эхэлсэн. Үүнээс шалтгаалж Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн жишиг болгон авдаг Баталгаат овернайт санхүүжилтийн түвшин (SOFR/СОФР) өсөж түүхэн дээд түвшиндээ ирсэн. Дараах графикаар СОФР хүүгийн түвшний түүхэн хэмжээг харуулав.

Түүнчлэн, Монгол Улсын хувьд 1991 оноос 2010 оны хооронд нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого 1,005 ам.доллароос бага тул бага-орлоготой орны ангилалд байсан бол 2011 онд тус үзүүлэлт 1,890 ам.долларт хүрч, бага дундаж орлоготой орны шалгуурыг хангасан бөгөөд 2023 оны байдлаар нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээ 4,950 ам.долларт хүрсэн тул дунджаас дээгүүр орлогын ангилалд (Upper middle income) хамаарч байна.

Үүнээс шалтгаалан Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээлдүүлэх зээлийн нөхцөл хөнгөлөлттэй нөхцөлөөс арилжааны нөхцөл рүү шилжиж байна. Тухайлбал, Монгол Улсын хамгийн томоохон зээлдүүлэгчийн нэг болох Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкууд зэрэг олон улсын байгууллагуудаас Монгол Улсад олгох нэн хөнгөлөлттэй эх үүсвэрийн хөнгөлөлтийг бууруулж, хөнгөлөлттэй эх үүсвэр болон энгийн эх үүсвэрийг холимог байдлаар олгож эхэлсэн.


Засгийн газрын хувьд 2023-2024 оны хооронд нийт 1,126.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний төслийн зээлийн гэрээ байгуулсан бол зээлдүүлэгч байгууллагуудтай хэлэлцээ хийсний үр дүнд үүнээс 643.0 сая ам.долларыг тогтмол хүйтэй нөхцөлөөр байгуулсан болно.

3.3 Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсөл, арга хэмжээг дэмжисж, тэдгээрийн санхүүжилтийг Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн өрийн хэрэгсэлтэй уялдуулж, Засгийн газрын өрийн зохицуулалтын арга хэмжээнд нэвтрүүлэх боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангуулахад холбогдох яамтай хамтран ажиллах, түүнчлэн эдгээр арга хэмжээний ач холбогдлыг олон нийтэд таниулах;

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Сангийн яамнаас Монгол Улсын тогтвортой хөгжил, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн

График № 3. Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин, хувь, 2020-2025 он

Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин, хувь, 2020-2025 он



санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн бондын баримт бичгийг 2023 онд боловсруулж Эс энд Пи олон улсын зээлжих зэрэглэлийн агентлагаар 2023 оны 1-р улиралд хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлсэн. Хөндлөнгийн үнэлгээгээр тус баримт бичиг нь олон улсын зарчмуудыг хангасан гэж үнэлэгдсэн бөгөөд тус үнэлгээ нь Эс энд Пи агентлагийн цахим хуудсанд 2023 оны 06 дугаар сард нийтлэгдсэн. Дээрх санхүүгийн шинэлэг хэрэгслийн ач холбогдлыг олон нийтэд таниулах ажлын хурээнд холбогдох сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулж цаашид олон улсын зах зээлд арилжаалах бэлтгэл ажлыг хангасан болно.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын (ХБНГУ) Сэргээн босголт, зээлийн банк (KfW) болон Глобаль сантай өр хөрвүүлэх хэлэлцээрт 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээрийг хийснээр Монгол Улсын Засгийн Газар ХБНГУ-ын KfW банканд төлөх өр төлбөрөөс 29.0 сая еврогийн дүнтэй тэнцэх төлбөрийг Монгол Улсад хэрэгжих ДОХ, гепатит, сүрьеэ өвчний эсрэг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зарцуулах боломж бүрдэж байна.

3.4 Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Засгийн газрын өрийн өгөгдлийн сан бүрдүүлэх, өрийн үйлчилгээ, ашиглалт, шинээр гаргалт, гэрээний мэдээллийг тухай бүр бүртгэх зорилгоор НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас боловсруулсан Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (ДМФАС)-ийг ашиглаж байна.

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд ДМФАС системийн нэмэлт хөгжүүлэлт болох Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний дэд систем “DMS”-ийг боловсруулсан. Энэхүү системийг ашигласнаар төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэж улсын секторын өрийн бүртгэлийг хийх боломжтой болж байгаа бөгөөд Засгийн газрын өрийн зардал эрсдэлийн үзүүлэлтүүдийг тооцож, өрийн үйлчилгээний хуваарийг татан хуваарьт хугацаанд санхүүжилтийн мэдэгдлийг боловсруулах зэрэг өрийн мэдээллийн санг илүү өргөн цар хүрээтэйгээр бүрдүүлэх боломжийг бий болгож байна.

3.5 Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу Засгийн газрын өрийн бүрэлдэхүүнд аймаг, нийслэлээс гаргасан өрийн хэрэгслийг бүртгэн тайлагнадаг. Үүний дагуу аймаг, нийслэлийн өрийн хэрэгслийн гаргалт, бүртгэл, тайлагналтай холбоотой арга зүйн зөвлөмжийг Сангийн яамны зүгээс тухай бүр өгч, тогтмол хамтран ажиллаж байна.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас, 500 сая ам.долларын гадаад үнэт цаасыг гаргаад байна. Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний систем ДМФАС-д өрийн хэрэгслийг бүртгэх, тайлагнах талаар сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр орсон бөгөөд Нийслэлийн үнэт цаасны мэдээллийг тус системд бүртгэх, үнэт цаасны эрсдэлийг удирдах, үнэт цаасны бүртгэл, төлбөр тооцооны талаар орон нутгийн өрийн удирдлагыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

4.1 Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтээт технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх;

Монгол Улс 1996 онд Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны нээлттэй зах зээлийн арилжааг эхлүүлэн, 2012 оноос төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг Монголбанкны Засгийн газрын үнэт цаасны арилжааны системээр тогтмол арилжаалж эхэлсэн. Түүнчлэн, 2014 оноос эхлэн Монголын хөрөнгийн биржээр “Миллениум Ай Ти” системийг ашиглан арилжаалж эхэлсэн бөгөөд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгалалтыг “Миллениум Ай Ти” систем болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн E-Clearing House системээр тус тус дамжуулан хийж байсан.

Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичигт заасны дагуу дээрх 2 системийн сүл талуудыг арилгасан шинэ системийг хөгжүүлэн ашиглах зорилтын хүрээнд 2023 оноос Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны систем болох “bond.mse.mn” системийг Монголын хөрөнгийн биржтэй хамтран хөгжүүлж, арилжааны банкууд болон үнэт цаасны компаниудтай хамтран туршилтыг хийж байна. Тус систем нь үнэт цаасны эргэн төлөлтийг бодож хөрөнгө оруулагчдад хүргүүлэх тул эргэн төлөлтөд зөрүү үүсэх асуудал үүсэх эрсдэлийг бууруулсан бөгөөд 2017 он хүртэл ашигласан системээс дараах давуу талуудтай. Үүнд:

1. Арилжааны мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТХТ/, Монголын Хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулагчидтай хуваалцах үйлдлийг автоматжуулах;
2. Арилжаа бүрийн мэдээллийг авах;
3. Хураангуй тайланг цаг алдалгүй харах;
4. Төлбөрийн тооцооллыг нэгдсэн байдлаар харах;
5. Үнэт цаасны хуваарилалтыг автоматаар хийх зэрэг боломжтой болсон.

4.2 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжсаа зохион байгуулагдахаас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй

зарлажс, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулах.

Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн Монголын хөрөнгийн биржтэй хамтран Засгийн газрын дотоод үнэт цаас /ЗГДҮЦ/-ны дэд бүтцийг сайжруулах хүрээнд “bond.mse.mn” анхдагч зах зээлийн арилжааны системийг хөгжүүлээд байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд дотоодын үнэт цаасны зах зээлийн хөгжүүлэх зорилгоор үнэт цаасыг нээлтгэй зах зээлд 300 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахаар тусгасан бөгөөд үүний дагуу 2025 оны 04 дүгээр сараас эхлэн Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг эхлүүлж 04 дүгээр сарын 16-ны өдөр 10 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас арилжаалаад байна. Ингэснээр 2025 онд дотоод үнэт цаасны арилжааг сар бүр 2 удаагийн зохион байгуулж, тогтмолжуулах төлөвлөгөөтэй байна.

4.3 Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч арилжаанд оролцсоноор бий болох үр ашиг, эрсдэлийн талаар иргэн, аж ахуйн нэгжийн мэдлэг, мэдээллийг дээшилүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх;

Засгийн газрын дотоод үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, дотоод үнэт цаасны бэлтгэл ажлыг хангах зорилгоор дараах үйл ажиллагаа, уулзалтуудыг зохион байгуулсан. Тухайлбал:

1. Монголын хөрөнгийн биржээр дамжуулан ЗГДҮЦ-ыг арилжаалж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сараас эхлэн ЗГДҮЦ-ны анхдагч арилжааны системийг хөгжүүлж эхэлсэн бөгөөд брокер дилерийн компаниудтай туршилтын арилжааг тухай бүр хийж, 2023 оны 10 дугаар сард “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг гүйцэтгүүлэх тухай заавар”-ыг хөрөнгө оруулагч нарт зориулан Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын А/24 дүгээр тушаалаар баталсан.
2. Сангийн яамнаас хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 10, 18 болон 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд 3 удаагийн туршилтын арилжааг арилжааны системд хийгээд байна. Түүнчлэн, ЗГДҮЦ-ны арилжаа, бэлэн байдалтай холбоотой 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр үнэт цаасны компаниудтай, 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр арилжааны банкуудтай уулзарт зохион байгуулж Засгийн газрын үнэт цаасны анхан шатны судалгаа хийж, үнэт цаасны арилжааны бэлтгэл ажлын талаар мэдээллийг өгсөн болно.
3. Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах хүрээнд үнэт цаасны дотоодын зах зээлд оролцогч хөрөнгө оруулагчдаас ЗГДҮЦ-ны зах зээлийн эрэлт болон хүлээлтийн талаарх тандан судалгааг 2024 оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 01-ний хооронд цахимаар хийсэн. Судалгаанд нийт

- 29 оролцогчоос хариу ирүүлснээс 9 арилжааны банк, 14 үнэт цаасны компани, 3 хувь хүн, 1 андеррайтер, 1 брокер, 1 банк бус санхүүгийн байгууллага байна.
4. Засгийн газрын дотоод үнэт цаасны 2025 оны 2 дугаар улирлын хуваарийг 2025 оны 03 дугаар сард Сангийн сайдын тушаалаар батлуулж, үүний дагуу 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны компаниуд, арилжааны банкууд болон дэд бүтцийн байгууллагуудыг хамруулсан уулзалтыг зохион байгуулсан. ЗГДҮЦ-ны арилжааны системийн бэлэн байдлыг хангах хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 09, 10, 14 өдрүүдэд туршилтын арилжааг гүйцэтгэж хөрөнгө оруулагч нарт зориулсан ЗГДҮЦ-ны талаар болон арилжаанд хэрэхэн оролцох талаар инфографик мэдээг олон нийтэд мэдээлсэн.

Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

5.1 Эдийн засаг болон нийгмийн үр өгөөжсөн өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;

Улсын Их Хурлын 2023 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 90 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөглжийн банк /МУХБ/-ны 420 сая юанийн зээлээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-д 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр өрийн баталгаа гаргасан. Уг төсөл хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 25,139 айл өрх, 3,133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын олборлох үйлдвэрүүдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангагдана. Түүнчлэн зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн томоохон байгууллагуудын хэрэгжүүлж буй төслүүдийн өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг хангахын зэрэгцээ цаашид төлөвлөсөн бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг байгаль орчинд ээлтэй технологи бүхий дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах ач холбогдолтой.

5.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсэжс болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайлагнах механизмыг бүрдүүлэх;

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 474 дүгээр тогтоолын хавсралтаар “Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам”-ыг баталсан. Үүний хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн улсын төсөвт үзүүлэх дарамтыг тооцох, эрсдэлийг үнэлэх механизмыг гаргасан болно. Мөн тус журамд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрөөс үзүүлэх дэмжлэг болох хөрөнгө оруулалт, эх үүсвэрийг улсын төсвөөс шийдвэрлэх, мөн төрөөс хариуцах газрын зөвшөөрөл, татварын хөнгөлөлт, худалдан авалт болон бусад асуудлыг тусгасан болно.

Түүнчлэн, Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл тооцох загварыг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан бөгөөд үүнийг Дэлхийн банкны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөвт үзүүлэх эрсдэлийн үнэлгээний загвар (PFRAM)-ыг ашиглаж боловсруулсан болно.

5.3 Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулэж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн тайлант хугацаанд Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг хийсэн байгууллагуудад жил бүр эрсдэлийн үнэлгээг хийн Үндэсний аудитын газарт хүргүүлж байна. Тухайлбал, 2023 онд “Эрдэнэс Монгол” ХХК болон Монгол Улсын Хөгжлийн банканд 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд, 2024 онд “Эрдэнэс Монгол” ХХК-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тус тус эрсдэлийн үнэлгээг хийсэн бөгөөд “маш бага” эрсдэлтэйгээр үнэлэгдэж Үндэсний аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 03/4976 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

Эрсдэлийн үнэлгээний дагуу дээрх байгууллагууд нь Засгийн газрын өрийн баталгаатай зээлийн төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлж барагдуулж байна. Тухайлбал, 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банк нь өрийн хөрөнгөөр 30 тэрбум иений хэмжээтэй “Самурай” бондын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-аас Азийн хөгжлийн банкнаас авч ашигласан Засгийн газрын өрийн баталгаатай зээлийн үлдэгдэл 8.6 сая ам.долларын төлбөрийг хугацаанаас өмнө буюу 2024 оны 10 дугаар сард эргэн төлж 2031 онд дуусах нөхцөлтэй зээлийг бүрэн төлж барагдуулсан болно.

Түүнчлэн, тус байгууллагуудаас гаргасан Засгийн газрын өрийн баталгаат зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих зорилгоор эргэн төлөлт, үлдэгдлийн мэдээллийг авч Засгийн газрын өрийн статистикийн мэдээ гаргахад ашиглаж байна.

5.4 Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх

Засгийн газраас стратегийн тайлангийн хэрэгжилтийн хугацаанд шинээр Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ байгуулаагүй бөгөөд шинээр өрийн бичиг /вексель/ гаргагүй болно.

Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “барих-шилжүүлэх” төрлийн түншлэлийн гэрээг байгуулах болон түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглохоор тусгасан.

Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

6.1 Улирал бүр Засгийн газрын өрийн төвхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх

Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг улирал бүр бэлтгэн Сангийн яамны цахим хуудсанд олон нийтэд ил тод байршуулж байна. Энэхүү товхимлыг mof.gov.mn цахим хуудаснаас харах боломжтой бөгөөд дараах мэдээллийг оруулж байна. Үүнд:

- ✓ Засгийн газрын өрийн үлдэгдэл
- ✓ Өрийн хэрэгсэл тус бүрээр (валютаар, эргэн төлөгдөх хугацаагаар, хүүгийн төрлөөр, зээлдүүлэгчээр)
- ✓ Засгийн газрын өрийн үйлчилгээ
- ✓ Зардал, эрсдэлийн шинжилгээ
- ✓ Засгийн газрын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээл
- ✓ Улсын секторын өрийн статистик (санхүүгийн бус байгууллагууд)

Түүнчлэн, Засгийн газрын өрийн улирлын мэдээллийг Үндэсний статистикийн хороонд хүргүүлж тайлагнаж байгаа бөгөөд Олон улсын валютын сангийн Олон улсын Засгийн газрын өрийн нэгтгэлд ашигладаг жишиг болох “E-GDDS” форматаар нэгтгүүлдэг болно. Мөн Дэлхийн банканд жилийн эцсийн тайланг хүргүүлж, тус байгууллагын журмын дагуу Өрийн тайлагналын системд Засгийн газрын өрийн мэдээллийг тайлагнаж байна.

6.2 Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх

Улсын секторын өрийн мэдээллийг “dms.mof.gov.mn” цахим системээр дамжуулж төрийн өмчит компаниудаас авч байгаа бөгөөд уг системд төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан 78 хуулийн этгээд бүртгэлтэй байна. ОУВС-ийн стандартын дагуу нийтэд хагас бүр Сангийн яамны цахим хуудсанд ил тод байдлаар тайлагнаж байна.

Түүнчлэн мэдээллийг нэгтгэсэн санг сайжруулах ажлыг зохион байгуулж E-balance санхүүгийн тайлангийн системд тогтсон загварыг үүсгэн байгууллагуудаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг боловсронгуй болгосон. Мөн тус системд бүртгэгдсэн мэдээллийг дэлгэрүүлж бүртгэлийг сайжруулах зорилгоор нэмэлт тайлбарыг “dms.mof.gov.mn” цахим системээр авч байгаа бөгөөд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өрийн мэдээллийг тус системээр дамжуулан олон улсын стандартын дагуу нэгтгэж, тайлагнаж байна.

4. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ БҮТЭЦ, ЗАРДАЛ ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ,

Засгийн газрын өрийн багцад хийсэн зардал эрсдэлийн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт № 8. Засгийн газрын өрийн багцын зардал эрсдэлийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Түвшин	2023	2024
Өрийн зардал			
Жигнэсэн дундаж хүү (хувь)	Гүйцэтгэл	3.5	4.3
	Дээд	3.8	4.3
Дахин санхүүжилтийн эрсдэл			
Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	Гүйцэтгэл	7.9	7.5
	Доод	7.8	7.3
Хүүгийн эрсдэл			
Засгийн газрын өрийн хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/	Гүйцэтгэл	7.1	6.5
	Доод	7.0	6.5
Ханшийн эрсдэл			
Гадаад валютаар илэрхийлсэн өр /нийт өрд эзлэх хувь/	Гүйцэтгэл	98.4	96.1
	Дээд	80.0	80.0

4.1 Өрийн зардал

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд буюу 2023-2025 онд хүүгийн түвшин өндөр Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй бөгөөд хөнгөлөлтгэй зээлээр төсвийн алдагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлого баримталсан.

Түүнчлэн олон улсад тулгарсан инфляцын өсөлтөөс шалтгаалж улс орнууд бодлогын хүүгээ өсгөсөнтэй холбоотойгоор гадаад зээлийн жишиг хүү болох Баталгаат овернайт хүүгийн түвшин түүхэн дээд хэмжээнд хүрч Засгийн газрын нийт өрийн 65 хувийг эзэлж буй гадаад зээлийн дундаж хүүгийн түвшин өссөн, мөн гадаад үнэт цаасны жишиг хүүгийн түвшин болох АНУ-ын Холбооны нөөц банкны бондын өгөөж өссөнтэй холбоотойгоор 2023 онд шинээр гаргасан үнэт цаас болох “Сенчири-2” болон “Сенчири-3” бондуудын хүүгийн түвшин өндөр байсантай холбоотойгоор гадаад үнэт цаасны хүүгийн түвшин өсөөд байна.

Ингэснээр Засгийн газрын өрийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2023 онд 3.5 хувь, 2024 онд 4.3 хувьтай тус тус тэнцээд байна.

4.2 Дахин санхүүжилтийн эрсдэл

Монгол Улсын эдийн засгийн хувьд Дэлхийн банкны аргачлалаар дундаас дээд түвшинд ирж олон улсын санхүүгийн байгууллагууд хугацаа өндөр буюу 30-40 жилийн

хугацаатайгаар олгодог байсан зээлийг 10-25 жилийн хугацаатай олгож эхэлсэн, мөн Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт улсын төсвийн орон зайнаас шалтгаалж удааширч байгаатай холбоотойгоор Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөгдөх дундаж хугацаа буурч байна.

Ингэснээр Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 2023 онд 7.9 жилтэй тэнцэж байсан бол 2024 онд 7.5 жилтэй тэнцэж буурсан байна.

4.3 Хүүгийн эрдэл

Монгол Улс дундаас дээш орлоготой орны ангилалд шилжсэнээр, мөн олон улсын байгууллагуудаас тогтмол хүүтэй санхүүжилтийн эх үүсвэрийг хөвөгч хүүтэй эх үүсвэрт шилжүүлснээс шалтгаалж гадаад зээлийн ашиглалтын ихэнх хувийг хөвөгч хүүтэй зээл эзэлж байна.

Ингэснээр Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа 2023 онд 7.1 жил, 2024 онд 6.5 жил болж буурсаар байна.

4.4 Ханшийн эрдэл

Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2017 оноос эхлэн арилжаалаагүй, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээллэгүүд нь гадаад валютаар илэрхийлэгдсэн, түүнчлэн Засгийн газрын дотоод үнэт цаасыг бага хэмжээгээр хаалттай хэлбэрээр арилжаалж байгаа тул Засгийн газрын нийт өрд эзлэх гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн хэмжээ 2023 онд 98.4 хувьтай, 2024 онд 96.1 хувьтай тус тус тэнцэж байна.

5. ЗАСГИЙН ГАЗРЫН ЗЭЭЛЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын зээллэгийн төлөвлөгөөг тухайн жилийн төсвийн тухай хуульд туссан Засгийн газрын үүсгэх өрийн дээд хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээнд тус тус үндэслэн боловсруулдаг болно.

Үүний дагуу Засгийн газрын 2023 оны зээллэгийн төлөвлөгөөг Засгийн газрын 2023 оны 104 дүгээр тогтоолоор, Засгийн газрын 2024 оны зээллэгийн төлөвлөгөөг Засгийн газрын 2024 оны 71 дүгээр тогтоолоор баталж төвсийн тодотгол хийсэнтэй холбоотойгоор 133 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан.

Засгийн газрын 2023, 2024 оны зээллэгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт № 9. Засгийн газрын 2023, 2024 оны зээллэгийн төлөвлөгөөний хэрэгжилт, тэрбум ₮

№	Зээлдүүлэгч	2023		2024	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Дотоод үнэт цаас	1,613.3	0.0	896.8	300.0
2	Гадаад үнэт цаас	4,025.0	3,457.0	1,775.0	0.0
3	Гадаад зээл	1,924.5	1,894.7	2,564.0	2,383.4
4	Орон нутгийн өр	0.0	0.0	2,700.0	2,508.2
	Нийт	7,562.8	5,351.7	7,935.8	5,191.6
5	Засгийн газрын өрийн баталгаа	3,730.3	0.0	3,550.0	1,907.0

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагуу гадаад зээлийн ашиглалт 1,924.5 тэрбум төгрөг, дотоод үнэт цаас гаргалтын хэмжээ 1,613.3 тэрбум төгрөг, дахин санхүүжилтийн зорилгоор гаргах гадаад үнэт цаасны хэмжээ 4,025.0 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байсан бол гүйцэтгэлээр гадаад зээлийн ашиглалт 1,894.7 тэрбум төгрөг, дотоод үнэт цаас гаргаагүй бөгөөд дахин санхүүжилтийн хүрээнд 3,457.0 тэрбум төгрөгийг гаргасан байна. Харин Засгийн газрын өрийн баталгаа 3,730.3 тэрбум төгрөгийг гаргахаар тусгасан бол 2023 онд гаргаагүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу гадаад зээлийн ашиглалт 2,564.0 тэрбум төгрөг, дотоод үнэт цаас гаргалтын хэмжээ 896.8 тэрбум төгрөг, дахин санхүүжилтийн зорилгоор гаргах гадаад үнэт цаасны хэмжээ 1,775.0 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байсан бол гүйцэтгэлээр гадаад зээлийн ашиглалт 2,383.4 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны гаргалт 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бөгөөд дахин санхүүжилтийн хүрээнд гадаад үнэт цаас гаргаагүй байна. Харин Засгийн газрын өрийн баталгаа 3,550.0 тэрбум төгрөгийг гаргахаар тусгасан бол 1,907.0 тэрбум төгрөгийн өрийн баталгаа гаргасан.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨРИЙН УДИРДЛАГЫН СТРАТЕГИЙН ДУНД ХУГАЦААНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ 2023-2024 ОНЫ БАЙДЛААР ХАНГАГДСАН ХЭДИЙ Ч ХАНШИЙН ЕСӨЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/03-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



УЛААНБААТАР 2025 он

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Д.Энхболд
Утас: 263755 Цахим хаяг: enkholbold@audit.gov.mn
Аудитын менежер Б.Саруул
Утас: 261805 Цахим хаяг: saruulb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батдэлгэр
Утас: 261675 Цахим хаяг: batdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор И.Туяадарь
Утас: 261675 Цахим хаяг: tuyadarii@audit.gov.mn
Аудитор М.Доржханд
Утас: 261675 Цахим хаяг: dorjkhandom@audit.gov.mn
Аудитор Б.Цэрэнхүү
Утас: 261675 Цахим хаяг: tserenkhuub@audit.gov.mn
Аудитор Г.Очирваань
Утас: 261675 Цахим хаяг: ochirvaanig@audit.gov.mn
Аудитор Т.Хандаймаа
Утас: 261675 Цахим хаяг: khandaimaat@audit.gov.mn
Аудитор М.Энхтөр
Утас: 261675 Цахим хаяг: enkhturm@audit.gov.mn



2025 03 31

Дугаар A/35

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажулах тухай

Терийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдвийг үндэслэн "Засгийн газрын ерийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням), олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол) нарт тус тус даалгасутай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (Л.Гантемер), Сангийн сайд (Б.Жавхлан), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар) нарт тус тус зөвлөсүгтэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд)-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хамгаж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт балтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хулээлгэн өгөхийг аудитын баг (Б.Саруул)-д үүрэг болгосугай.

Д ЗАГДЖАВ

АГУУЛГА

Товчилсон үгсийн тайлал.....	4
Хүснэгтийн жагсаалт	4
Графикийн жагсаалт.....	5
Дурслэлийн жагсаалт.....	5
Хавсралтын жагсаалт.....	5
 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	 8
 БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД НИЙЦҮҮЛЖ БОЛОВСРУУЛСАН Ч САЙЖРУУЛАХ АСУУДЛУУД БАЙСААР БАЙНА	 11
Оршил.....	11
Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж баталсан ч Өрийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх арга хэмжээ аваагүй байна.....	11
Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланы хуульд нийцүүлэн тайлагнасан байна.....	12
Өрийн төсөөт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор төсвийн тогтвортой байдлыг хангаж, гадаад өрийн удирдлагад болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолох нь зүйтэй байна.....	15
Засгийн газраас 2023-2024 онд өрийн үйлчилгээний зардалд нийт 9,612.8 тэрбум төгрөг төлсөн байна.....	16
 БҮЛЭГ 2. ӨРИЙН УДИРДЛАГЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ ХОЙШЛУУЛСАН Ч ДАХИН САНХҮҮЖИЛТ, ХАНШИЙН ЭРСДЭЛТЭЙ ХЭВЭЭР БАЙНА	 18
Оршил.....	18
Зорилт 1. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй, хөгжлийн бодлогод туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр гадаад зээл авч байгаа ч Өрийн удирдлагын тухай хуулийн зарчмуудыг баримтлах шаардлагатай байна	18
Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөөт дарамт учруулахгүйгээр дахин санхүүжилт хийж, зээлжих зэрэглэл ахисан байна.....	21
Зорилт 3. Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор тодорхой ажлууд хийгдсэн ч гадаад зах зээлийн таагүй байдал, орон нутгийн өр төлбөрийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх шаардлагатай байна.....	23
Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих үнэт цаасны арилжаа 2023-2024 онд хийгдээгүй байна	25
Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан ч хувийн хэвшлийн компаниуд хүсэлт ирүүлээгүйгээс тэдэнд дэмжлэг үзүүлэх өрийн баталгаа гарваагүй байна.....	26
Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулсан ч мэдээллийг нэг нэгдсэн стандарттаар гаргах шаардлагатай байна	27
Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтын ханшийн эрсдэлийн зорилт хангагдаагүй байна.....	28
 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	 31
 САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:	 35
 ДҮГНЭЛТ.....	 36
 ЗӨВЛӨМЖ	 38
 ХАВСРАЛТУУД	 39

Товчилсон үгсийн тайлал

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын стандарт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
АХБ	Азийн хөгжлийн банк
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БНАУ	Бүгд Найрамдах Австри Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БСҮХ	Боомтын сэргэлтийн үндэсний хороо
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТЭ	Зээлжих Тусгай эрх
ЗТЯ	Зам тээврийн яам
МВт	Мегаватт
МУХБ	Монгол улсын Хөгжлийн банк
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
TX3	Тогтвортой хөгжлийн зорилго
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УЦС	Усан цахилгаан станц
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХААХҮЯ	Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦХХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын нийт гадаад өрийн статистик, 2022-2024 онд, сая ам.доллар, тэрбум төгрөгөөр	8
Хүснэгт 2	Засгийн газрын өр, 2022-2024 он, тэрбум төгрөг	9
Хүснэгт 3	Гадаад үнэт цаасны үлдэгдэл, тэрбум төгрөг	9
Хүснэгт 4	Стратегийн баримт бичгийн тайлангийн агуулга хуульд нийцсэн эсэх судалгаа	13
Хүснэгт 5	Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс, /ДНБ-д харьцуулсан өрийн хэмжээний ёсөлт бууралтын хувь/	15
Хүснэгт 6	Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал, тэрбум төгрөгөөр	17
Хүснэгт 7	НЗДТГ-аас гаргасан үнэт цаасны мэдээлэл	20
Хүснэгт 8	Дунд хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээ	22

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 9	Хадгаламж болон хадгаламжийн хүүгийн өсөлт	26
Хүснэгт 10	Засгийн газрын өрийн мэдээллийн зөрүүтэй байдал	28
Хүснэгт 11	Засгийн газрын өрийн багцын зардал эрсдэлийн шинжилгээний үр дүн	28
Хүснэгт 12	Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээний үр дүн, НЭДТГ-аас гаргасан бондын нөлөөг тооцсоноор	30

Графикийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
График 1	Дотоод үнэт цаасны үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	9
График 2	ДНБ, нэрлэсэн үнээр болон 2015 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	15
График 3	Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, хувиар	16
График 4	Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал, тэрбум төгрөг	16
График 5	Гадаад зээлийн 2023-2024 оны ашиглалтын салбараар ангилсан үзүүлэлтүүд	19
График 6	Гадаад үнэт цаасны үлдэгдлийн өөрчлөлт /хуримтлагдсан хүү хасаж тооцсоноор/, сая ам.доллар	21
График 7	Засгийн газрын гаргасан гадаад бондын өгөөж, хувиар	22
График 8	Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин, хувь, 2022-2025 он	24
График 9	Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа, /жилээр/	29

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дунд хугацааны стратегийн зорилт	13
Дүрслэл 2	Дунд хугацааны стратегийн зорилт 3-ын хүрээнд хийгдэх ажлууд	23

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хавсралт 1	Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт, хэрэгжүүлэх арга замын хэрэгжилт	39
Хавсралт 2	Өрийн удирдлагын тухай хуулийн 14.3 дахь заалт, Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги боловсруулах удирдамж, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн агуулгын харьцуулалт	41
Хавсралт 3	Төсвийн хүрээний мэдэгдэл нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал	42
Хавсралт 4	Гадаад бондын үлдэгдэл, сая ам.доллар	42

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдвийн дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд гүйцэтгэл-нийцлийн аудит хийлгээ.

Аудитын зорилго, хамарсан хүрээ

Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилт, түүний үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Үүнд:

- Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдэд нийцсэн эсэх;
- Засгийн газрын дунд хугацааны өрийн удирдлагын эрсдэл бууруулах арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитаар Засгийн газрын 2023-2025 оны өрийн байдал, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн судалгаа, шинжилгээ хийж, нотлох баримтад үндэслэн Засгийн газрын өрийн удирдлагын харгалзах оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэж, үнэлэлт өглөө.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-5:2020 Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020 Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны A/69 дүгээр тушаалаар баталсан Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, GUID 5250 (Guidance on the Audit of Public Debt)-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа гаргуулах, харьцуулах, нэгтгэх зэргээр дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан төлөвлөсөн арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль тогтоомжийг аудитын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

УИХ-аас баталсан хуулиуд:

- Өрийн удирдлагын тухай;
- Өрийн удирдлагын хуулийг дагаж мөрдөх журмын тухай;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай;
- Төсвийн тогтвортой байдлын тухай;
- Төсвийн тухай;

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай;
- Валютын зохицуулалтын тухай;
- Үнэт цаасны зах зээлийн тухай;
- Олон улсын гэрээний тухай;
- Шилэн дансны тухай;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиуд;
- Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл (2023-2025)
- Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг (УИХ-ын 2022 оны 26 дугаар тогтоол)

Засгийн газраас баталсан журмууд:

- Засгийн газрын гадаад үнэт цаас гаргах, арилжаалах журам;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам;
- Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам;
- Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам;
- Өрийн удирдлагын зөвлөлийн ажиллах журам;
- Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам;

Сангийн сайдын баталсан журмууд:

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам;
- Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, төвлөрүүлэх, өр төлбөрийг бүртгэх, тайлагнах журам;

Бусад:

- Өрийн статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал;
- Дээрх хууль тогтоомжтой холбоотой бусад хууль тогтоомжууд.

Аудитын баг, бүрэлдэхүүн

Аудитыг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, аудитын менежер Б.Саруул аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батдэлгэр, И.Туядарь, аудитор М.Доржханд, Б.Цэрэнхүү, Г.Очирваань, Т.Хандаймаа, М.Энхтөр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т "Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 3 дугаар сарын 01-ний дотор гаргаж төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба уг тайланд төрийн аудитын төв байгууллага 4 дүгээр сарын 01-ний дотор аудит хийнэ" гэж заасны дагуу Сангийн яамнаас 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/512 дугаар албан бичгээр Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг ирүүлсэн байна.

Аудит хийх хугацаанд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, түүний дотор өрийн үлдэгдэл аудитаар баталгаажих, ДНБ-ий 2024 оны статистик үзүүлэлтийг нийтэд тархаах хугацаа болоогүй, мөн дээрх стратегийн зорилтуудын хэрэгжилт дуусаагүй байгаа тул 2023-2024 оны явцын бүрэн бус мэдээлэлд тулгуурлан аудитаар нэгдсэн дүгнэлт гаргахад хүндрэлтэй байлаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн баримт бичгийг боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглааврын дагуу батлуулна” гэж зааснаар УИХ-аас Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг 2022 оны 26 дугаар тогтоолоор баталсан байна.

Энэхүү стратегийг 2016 оноос хойш 3 дахь удаагаа батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болохоор байна.

Улсын нийт гадаад өр

Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.4-т “улсын нийт гадаад өр” гэж Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үргийг гэж заасны дагуу “улсын нийт гадаад өр¹”-ийг бүртгэж, тайлагнаж байна.

Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 37.1 тэрбум ам.доллар болж 2022 оноос 11.3 хувиар өссөн байна. Өрийг бүтцээр задалж харвал, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 0.1 тэрбум, Төв банкны гадаад өрийн үлдэгдэл 1.1 тэрбум, бусад салбаруудын өрийн үлдэгдэл 0.2 тэрбум ам.доллараар тус тус буурсан бол Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын өрийн үлдэгдэл 1.1 тэрбум, аж ахуйн нэгж хоорондын зээллэгийн үлдэгдэл 4.1 тэрбум ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Улсын нийт гадаад өрийн статистик, 2022-2024 оны байдлаар, сая ам.доллар, тэрбум төгрөгөөр

Салбарын ангилал	2022 он		2023 он		2024 он	
	ам.доллар	төгрөг	ам.доллар	төгрөг	ам.доллар	Төгрөг
Засгийн газар	8,012.5	27,599.9	8,105.1	27,644.0	7,887.6	26,979.2
Төв банк	2,179.0	7,505.8	1,784.8	6,087.4	1,086.3	3,715.6
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,532.6	5,279.2	1,733.2	5,911.4	2,657.0	9,088.2
Бусад салбарууд	8,436.0	29,058.6	7,865.8	26,827.8	8,235.1	28,167.8
Аж ахуйн нэгж хоорондын зээллэг шууд хөрөнгө оруулалт	13,184.8	45,416.4	15,080.6	51,435.3	17,254.3	59,017.6
Нийт гадаад өр	33,344.9	114,859.8	34,569.5	117,905.8	37,120.3	126,968.5

Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 33,384.6 тэрбум төгрөг, ДНБ-д харьцуулсан харьцаа 41.8 хувьтай тэнцэж байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл өмнөх оноос 1,310.9 тэрбум, орон нутгийн зээллэг 2,546.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, харин дотоод үнэт цаас 635.0 тэрбум, гадаад үнэт цаас 704.8 тэрбум, өрийн баталгаа 634.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

¹ Монголбанк болон Сангийн яам хамтран улсын нийт гадаад өрийг Олон Улсын Валютын сан /ОУВС/-ийн статистик боловсруулах 6 дугаар гарын авлагыг үндэслэлн “Монгол Улсын төлбөрийн тэнцилийг боловсруулах аргачлал”-ыг боловсруулж, энэ хүрээнд мэдээлэл түгээх өрөнхий шаардлагын дагуу 2010 оноос эхлэн олон нийтэд мэдээлж байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Засгийн газрын өр, 2022-2024 он, тэрбум төгрөг

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл ²	2022 он	2023 он	2024 он*
1. Засгийн газрын дотоод өр	1,035.5	234.1	400.5
1.1. Үнэт цаас	1,035.5	234.1	400.5
2. Засгийн газрын гадаад өр	29,641.6	30,274.6	30,247.8
2.1. Үнэт цаас	9,359.8	9,371.7	8,655.0
2.2. Зээл	20,281.8	20,902.9	21,592.7
3. Бусад өр төлбөр	1,288.7	264.8	2,736.4
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	812.9	29.5	178.0
3.2. Орон нутгийн өр	463.5	4.5	2,558.4
3.3. Концесс (барих-шилжүүлэх)	12.3	230.9	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	31,965.8	30,773.5	33,384.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	27,691.6	26,582.9	-
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар	70.0%	65.0% (ӨҮЦ)	60.0% (Нэрлэсэн)
Засгийн газрын өр / ДНБ	59.4%	43.7%	41.8%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	58.2%	37.7%	-

*Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар 2023 онд 692.5 тэрбум төгрөгийн гадаад зээл, 2024 онд урьдчилсан гүйцэтгэлээр 341.8 тэрбум төгрөгийн гадаад зээл, 300.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас, нийт 1,434.3 тэрбум төгрөгийн зээллэг хийсэн байна.

Дотоод үнэт цаас

Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд нээлттэй үнэт цаас арилжаалаагүй байна. Харин төлбөрийн үүргийг хуваарийн дагуу гүйцэтгэж байгаа бөгөөд 2022 онд 1,035.5 тэрбум төгрөг байсан 2024 оны жилийн эцсийн байдлаар 400.5 тэрбум төгрөг болж буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Сангийн сайдын 202 дугаар “Засгийн газрын үнэт цаас хаалттай гаргах тухай” тушаалаар Сангийн яам, НДЕГ 199/НД73/24 дугаар гэрээг байгуулан нийгмийн даатгалын санд дотоод үнэт цаас арилжаалсан байна. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилготой энэхүү үнэт цаас нь 3 транчтай бөгөөд нийт 300.0 тэрбум төгрөгийн үнийн дүн, 1-3 жилийн хугацаатай, 8.5-9.5 хувийн хүйтэй байна.

Гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны нэрлэсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцэст 2,530.5 сая ам.доллар буюу 8,655.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 3. Гадаад үнэт цаасны үлдэгдэл, тэрбум төгрөг

д/д	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Эргэн төлөх огноо	Үлдэгдэл	
					ам.доллар	Төгрөг
1	Номад	5.125%	5.5 жил	2026.04.07	572.7	1,958.7
2	Сенчири-1 2027*	3.500%	6 жил	2027.07.07	420.1	1,436.8

* Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжик эхэлсэнтэй холбоотойгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дэх хэсэг хүчинчүй болсон. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг өнөөгийн үнэ цэнээр илрхийлдэг байсныг нэрлэсэн үлдэгдэл болгож өөрчлсөн байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратөгийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

3	Сенчири-1	2031`	4.450%	10 жил	2031.07.07	510.7	1,746.7
4	Сенчири-2		8.650%	5 жил	2028.01.19	675.1	2,309.2
5	Сенчири-3		7.875%	5.5 жил	2029.06.05	351.9	1,203.6
		НИЙТ				2,530.5	8,655.0

Эх сурвалж: Сангийн яам

Гадаад зээл

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6,313.2 сая ам.доллар буюу 21,592.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд 2023-2024 онд нийт 3,255.9 тэрбум төгрөгийг, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 1,034.3 тэрбум төгрөг, нийт 4,290.2 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авч ашигласан байна.

Засгийн газрын өрийн баталгаа

Монгол Улсын Хөгжлийн банк “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх” төслийн санхүүжилтэд БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авч ашигласан 420.0 сая юанийн зээлд 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр гаргасан Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 178.0 тэрбум төгрөг байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дугаар зүйлийн 28¹.1-т заасны дагуу НЗДТГ-аас олон улсын зах зээлд арилжаалсан “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад шаардлагатай 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байна. Энэ өрийн баталгааг орон нутгийн өрийн жагсаалтад бүртгэсэн байна.

Орон нутгийн өр

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд:

- “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон “Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил” төслийдийг санхүүжүүлэхэд 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас;
- “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхэд 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг тус тус гаргасан байна.

Орон нутгийн өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2,558.4 тэрбум төгрөг байна.

БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД НИЙЦҮҮЛЖ БОЛОВСРУУЛСАН Ч САЙЖРУУЛАХ АСУУДЛУУД БАЙСААР БАЙНА

Оршил

Өрийн удирдлагын тухай хуульд Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг бодлогын баримт бичгээр тодорхойлохоор заасан ба тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д өрийн удирдлагын стратегийн зорилгыг “макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чиглэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Засгийн газар 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийг боловсруулж, улсын өрийн тогтвортой байдлыг хангах, зээлжих чадварыг сайжруулах, дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлд бодлого хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Энэхүү бүлэгт стратегийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа Өрийн удирдлагын тухай хуульд нийцсэн эсэх болон сайжруулах асуудлуудыг тодорхойлоход чиглүүллээ.

Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж баталсан ч Өрийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх арга хэмжээ аваагүй байна

1.1 Сангийн яам Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг Олон улсын валютын сан болон Дэлхийн банкнаас хамтран 2019 онд гаргасан “Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги боловсруулах удирдамж” болон Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасны дагуу боловсруулсан байна.

1.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т Стратегийн баримт бичигт дараах зүйлийг тусгахаар заасан байна. Үүнд:

- Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн тухайн үеийн нөхцөл байдал;
- Засгийн газрын өрийн шалгуур үзүүлэлтийн дунд хугацааны төсөөлөл;
- Санхүүжилтийн боломжит эх үүсвэр;
- Засгийн газрын өрийн багцад дунд хугацаанд нөлөөлөх хүчин зүйлс;
- Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн таамаглал;
- Засгийн газрын өрийн баталгааны багцын тухайн үеийн нөхцөл байдал, өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн таамаглал;
- Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтэц;
- Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга зам, өрийн зохицуулалтын үйл ажиллагаа;
- Бусад.

1.3 Дээрх олон улсын банк, санхүүгийн байгууллагаас санал болгосон өрийн удирдлагын стратеги боловсруулах удирдамжид дараах зүйлсийг тусгах талаар тодорхойлжээ. Үүнд:

- Өрийн удирдлагын зорилго, хамрах хүрээ;
- Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал;
- Санхүүжилтийн эх үүсвэрүүдийн шинжилгээ;
- Макро эдийн засгийн урьдчилсан төлөв;
- Боломжит стратегиудын үнэлгээ;
- Өрийн удирдлагын суурь стратеги;
- Стратегийн хэрэгжилт, хяналт.

1.4 Стратегийн баримт бичгийг боловсруулах гол зорилго нь оновчтой, эрсдэл багатай стратегийг сонгоход чиглэх билээ. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт боломжит стратегиудыг тодорхойлсон ч гол баримтлах зохистой

стратегиа³ яагаад хэрэгжүүлэх болсон үндэслэлийг тодорхойлоогүй, хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтгүй нь өрийн удирдлагын оновчтой төлөвлөлт хийсэн эсэх, бодлогын хэрэгжилтийг үнэлэх, хянах нөхцөлийг бууруулж байна.

Шигтгээ 1. Дэлхийн банкны орлогын ангиллаар дунджаас дээгүүр орлоготой улсын ангилалд байдаг улсуудын өрийн дунд хугацааны стратегийн бичиг баримтад зохицой стратегийг сонгосон байдал

- *Финансын “Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги 2024-2026”:*
... Стратегийн боломжит 4 хувилбарыг харьцуулсны үр дунд i) Засгийн газрын үнэт цаасны зах зээлийн эрэлт болон олон улсын зээлдүүлэгчдээс санхүүжилт авах боломж, ii) бодлогын зорилтот үзүүлэлтүүдтэй нийцэж буй байдал болон iii) стратегийн боломжит хувилбаруудын зардал-эрсдэлийн шинжилгээг харгалзан Нэгдүгээр стратегийг сонголоо. ...гэж;
- *Албаны улсын “Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги 2022-2026”:*
... Дээрх шинжилгээний дүгнэлтээс үзэхэд, өрийн санхүүжилтийн хувьд Гуравдугаар стратегийг сонгон хэрэгжүүлэх нь өрийн бутцийн ба зардал-эрсдэлийн тэнцвэрийг хангахад зохицой үр дунтэй байхыг харуулж байна. ...гэж;
- *Гренадын улсын “Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги 2022-2024”:*
... Эдийн засгийн шилжилт, тэсвэртэй байдлыг бий болгоход чиглэсэн гадаад хөнгөлөлттэй зээлд голчлон чиглэсэн Гуравдугаар стратеги нь зардал-эрсдэлийн шинжилгээний хувьд бусад боломжит стратегиудаасаа хамгийн тохиромжтой нь ба өрийн удирдлагын зорилтуудыг хамгийн сайн тусгасан стратеги юм. ... гэж тус тус голлох стратегиа тодорхойлсон үндэслэлээ тусгаж өгсөн хэрэгжүүлж болох туршлага байдал байна.

Эх сурвалж: Тухайн улсын өрийн дунд хугацааны стратегиуд⁴

1.5 Иймд 2026-2028 оны стратегийн баримт бичгийг боловсруулахдаа үндсэн стратегийг сонгох болсон шалтгаан нөхцөл, дэвшүүлсэн зорилтуудын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь тус бичиг баримтыг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах боломжийг нэмэгдүүлэх давуу талтай байна.

1.6 Өрийн удирдлагын зөвлөл 2023-2024 онд хуралдаагүй, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг боловсруулах үед төслийг, мөн хэрэгжилтийн хугацаанд явцыг дүгнэн зөвлөмж гаргаагүй нь Өрийн удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2⁵-т заасан чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

1.7 Харин Төсвийн тогтвортой байдлын Зөвлөл Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн төсөлтэй танилцаад санал, дүгнэлтийг 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцэн УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байна.

1.8 Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 31 дүгээр тушаалаар Өрийн удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Өрийн удирдлагын зөвлөл хуралдаж, Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн төсөлд зөвлөмж гаргасан нь хуульд нийцсэн байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хуульд нийцүүлэн тайлагнасан байна

1.9 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт өрийн удирдлагын дунд хугацаанд дараах 6 бодлогын зорилтыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх - 23 арга замыг⁶ тодорхойлсон байна. Үүнд:

Дурслэл 1. Дунд хугацааны стратегийн зорилт

³ Засгийн газрын өрийн удирдлагын бодлогын хурээнд хамгийн оновчтой, тогтвортой, эрсдэл багатай гэж тодорхойлсон, дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг хэлнэ.

⁴ <https://www.finance.gov.fj/wp-content/uploads/2024/02/Medium-Term-Debt-Management-Strategy-for-FY-2024-2026.pdf> (хуудас 27)
<https://financa.gov.al/wp-content/uploads/2024/02/2022-2026-Medium-Term-Debt-Management-Strategy-ENG.pdf> (хуудас 23)
<https://www.nowgrenada.com/wp-content/uploads/2021/12/Medium-Term-Debt-Strategy-REPORT-Final-2022-2024-Final-1.pdf> (хуудас 16), <https://data.worldbank.org/income-level/upper-middle-income?view=chart>

⁵ 21.2 Зөвлөл нь дараах асуудлаар зөвлөмж гаргана: 21.2.1 Засгийн газрын өрийн удирдлагын бодлого: 21.2.2 Стратегийн баримт бичгийн төсөл; 21.2.3 стратегийн баримт бичгийн хэрэгжилт; 21.2.4 өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл; 21.2.5 Засгийн газрын өрийн зохицуулалтын үйл ажиллагаа

⁶ Бүлэг 2-т зорилт, хэрэгжүүлэх арга замын дугаарыг ашиглах тул энэхүү дурслэлийг анхаарна уу.

Зорилт 1. Хэрэгжүүлэх арга замын тоо 3

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслийдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

Зорилт 2. Хэрэгжүүлэх арга замын тоо 4

Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

Зорилт 3. Хэрэгжүүлэх арга замын тоо 5

Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

Зорилт 4. Хэрэгжүүлэх арга замын тоо 4

Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

Зорилт 5. Хэрэгжүүлэх арга замын тоо 5

Улсын стратегийн томоохон төслийдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

Зорилт 6. Хэрэгжүүлэх арга замын тоо 2

Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

Эх сурвалж: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг

1.10 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 2023-2024 оны хэрэгжилтийн тайланд Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланд тусгах зүйлийг оруулж тайлагнасан байна.

Хүснэгт 4. Стратегийн баримт бичгийн тайлангийн агуулга хуульд нийцсэн эсэх судалгаа

Хуулийн заалт	Тайлагнасан эсэх
Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн талаарх мэдээлэл	Тийм
Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлийн шинжилгээ, түүний тайлбар	Тийм
Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтэц, түүний хэрэгжилт	Тийм
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4 ⁷ -т заасан хяглаарыг хангасан байдал	Тийм
Зээлэгийн төлөвлөгөөний хэрэгжилт	Тийм

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.11 Сангийн яам Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 2023 оны хэрэгжилтийн явцын тайланг Сангийн сайдын 2024 оны 01/4998 дугаар албан бичгээр УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байна. Харин Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д стратегийн баримт бичгийн явцын тайланг жил бүр гаргаж, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт Засгийн газарт 2024 оны 01/4854 дүгээр албан бичгээр явцын тайланг хүргүүлсэн байна.

1.12 Аудитад хамрагдсан хугацаанд Өрийн удирдлагын тухай хуульд 2023 онд 1, 2024 онд 2, нийт 3 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 2020 оны хуулийн шинэчилсэн найруулгаар тэдгээрийн хөгжлийн эдийн засгийн үндсийг бурдүүлэх зорилгоор 15 дугаар зүйлийн 15.1.6-д “хуульд заасан үндэслэл, журмын дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн саналыг хэлэлцэх, үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн цргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх”, мөн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар 13, 44 дүгээр зүйлд нийслэл үнэт цаас гаргаж, тусгай бүсийн дэд бүтцийн тесэл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр заасан зэргийг үндэслэн Хуулийн 6 дугаар зүйл өрийн удирдлагын хэсэгт баримтлах зарчмуудтай холбоотой заалтуудыг нэмж оруулсан байна. Ингэснээр орон нутгийн зээллэг, Засгийн газрын баталгааны үндсэн дээр хэрэгжих төсөл, хөтөлбөр нь үр ашигтай нь нотлогдсон байх, тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх, улс, олон улсын байгууллага болон банк, санхүүгийн байгууллагаас зээл авах аливаа гэрээ, түүнд оруулсан өөрчлөлт, төсөл, хөтөлбөрийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлэхээр заасан байна.

⁷ 6.1.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувис хэтрэхгүй байх.

- Мөн хуулийн дээрх зарчмын 6.5.1 дэх мэдээллийн ил тод байдлыг хангах хэсэгт улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “тогтоосон хугацаанд” гэж заасныг “улирал тутам” мэдээлж байхаар хугацааг тодорхой болгожээ.
- Хуулийн 13 дугаар зүйл Засгийн газрын өрийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэх хэсгийн 13.2.2-т өрийн удирдлагын зорилт, өрийн хэмжээ, өрийн багцын бүтэц, эрсдэлийг богино, дунд хугацаагаар тодорхойлохоор байсан “урт” хугацаанд төлөвлөх агуулгыг нэмж оруулсан байна.

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлтээр:

- Хууль санаачлагч “дотоодын өрийн хэрэгсэл зардал ихтэй, хүү өндөртэй, харин дэлхийн улс орнууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн ногоон зээл болон бондыг 2.0 орчим хувийн харьцуангуй бага хүүтэй санал болгож байгаа” үндэслэлээр хуулийн 28¹ дугаар зүйлийн 281.1-д “дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно” гэсний дараа “Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно” гэсэн заалтыг нэмж оруулсан байна.

2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн өөрчлөлтөөр:

- Хуулийн 40 дүгээр зүйл өрийн бүртгэл хэсэгт Засгийн газрын өрийн хязгаарыг нэрлэсэн дүнгээр тооцож, бүртгэхээр өөрчлөлт оруулсан.

1.13 Өрийн удирдлагын тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болох өөрчлөлт орсноор Засгийн газрын баталгаатайгаар НЭДТГ-аас олон улсын зах зээлд 500.0 сая ам.долларын үнэт цаас гаргасан байна.

1.14 Уг гадаад бондын хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн “Сэлбэ дэд төв” төслийн эргэн төлөлтийн эх үүсвэр нь дуудлага худалдаагаар борлуулах газрын орлогоос хамаарах зохицуулалттай байна. ҮАГ-аас 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 1450 дугаар албан бичгээр хүргүүлсэн “Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах төслийн эрсдэлийн үнэлгээнд хийсэн аудитын дүгнэлтэд” уг төлөвлөгөө нь санхүүжилтийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй онцолсон. Энэ нь НЭДТГ-ын өрийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж, тэр дундаа эрсдэлийн удирдлагын⁸ чадавхыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

1.15 Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ болон хуулийн өөрчлөлт нь хууль хоорондын нийцэлгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал,

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр өөрчлөлтөөр 6.2 дахь заалт хүчингүй болсон байхад Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.6-д “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.2⁹-т заасан мэдээллийг өрийн мэдээллийн санд бүртгэх” заалт хүчинтэй хэвээр, зохицуулалт хийгдээгүй байна.
- Сангийн сайдын тушаалаар шинэчлэн баталсан Өрийн удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16¹.1¹⁰, 16¹.25¹¹, Өрийн удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4¹²-т заасантай нийцэхгүй байна. Иймд тухайн гишүүн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл эсвэл Өрийн удирдлагын зөвлөлийн аль нэгийг сонгон ажиллаж, холбогдох хуулийн заалтыг мөрдөх нь зүйтэй байна.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас “Нийслэлийн гадаад үнэт цаас гаргахыг дэмжих тухай” төслийг Нийслэлийн ИТХ-д 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр хүргүүлж, Нийслэлийн ИТХ-аас 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Нийслэлийн гадаад үнэт

⁸ Өрийн удирдлагын дунд оффис

⁹ 6.2. Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаар нь эрчим хүч, төмөр зам, уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлуулсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашигас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энхэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй.

¹⁰ 16¹.1.УИХ-аас Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангуулах үүрэг бүхий хараат бус, бие даасан, байнгын ажиллагаатай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх-/ийг байгуулна.

¹¹ 16¹.25. Зөвлөлийн дарга, гишүүн нь шууд болон шууд бус хэлбэрээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хуульд өөрөөр заагаагүй бол өөр ажил, албан тушаал хавсрсан эрхлэхийг хориглоно.

¹² 21.4. Зөвлөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагчны төв байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аюулагыг байдлын зөвлөл болон санхүү, эдийн засгийн салбарын мэргэшсэн сублаачдын төлөөллийг оролцуулан есөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүний дэргэд байгуулна.

цаас гаргахыг дэмжих тухай" 47 дугаар тогтоолыг гаргасан байна. Харин УИХ-аас "Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай" 17 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан байна. Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.4¹³-т гэж заасантай нийцэхгүй байна.

Өрийн төсөөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор төсвийн тогтвортой байдлыг хангаж, гадаад өрийн удирдлагад болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолох нь зүйтэй байна

1.16 Дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулж байх үед Сангийн яам 2023-2025 оны Засгийн газрын өрийн үлдэгдэл, ДНБ-ний харьцаа хэрхэн өсөж, буурахаар байгаа төсөөллийг боловсруулж, цаашид баримтлах стратегийн зорилтыг гаргасан байна. Энэхүү төсөөллийн гүйцэтгэлийг харвал дараах байдалтай байна. Үүнд,

Хүснэгт 5. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс, /ДНБ-д харьцуулсан өрийн хэмжээний өсөлт бууралтын хувь/

Нөлөөлөгч хүчин зүйлс	2023		2024		2025	
	Төсөөлөл	Гүйцэтгэл	Төсөөлөл	Гүйцэтгэл	Төсөөлөл	Төсөөлөл
Баталгааны үлдэгдлийн өөрчлөлт	3.40	-2.06	-0.84	3.04	-1.03	3.10
Тайлбарлаагч үлдэгдэл	0.00	0.45	0.00	0.55	0.00	0.00
Бусад өр үүсэгч хүчин зүйлс	-0.92	0.00	-5.20	0.00	-4.18	0.00
Валютын ханшийн супрал	2.57	-0.40	1.21	0.09	0.94	1.58
Бодит хүүгийн түвшин	-2.60	-7.75	-1.50	-1.90	-1.64	-2.50
Бодит ДНБ-ий өсөлт	-2.62	-3.35	-2.99	-1.91	-3.39	-2.55
Төсвийн тэнцэл /хүүгийн зардлыг цэвэрлэсэн/	3.24	-2.70	5.10	-2.80	5.10	-1.00
Засгийн газрын өрийн өөрчлөлт	3.07	-15.78	-4.22	-2.93	-4.20	-1.34


Эх сурвалж: Сангийн яам

1.17 Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2023 онд 43.7, 2024 онд 41.8 байгаа нь Засгийн газар өрийн баталгааны үлдэгдэл буурсан, ханшийн супрал харьцангуй тогтвортой байсан¹⁴, бодит хүүгийн түвшин буурсан, бодит ДНБ өссөн, төсөв алдагдалгүй баталсан зэрэг үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

1.18 Ирээдүйн өрийн дарамтыг бууруулахын тулд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төсвийн алдагдлыг бууруулах, валютын ханшийг тогтвортжуулах чиглэлээр хатуу бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.19 ДНБ-ий өсөлтийг сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2015 оноос 2024 оны байдлаар авч үзэхэд дараах байдалтай байна.

График 2. ДНБ, нэрлэсэн үнээр болон 2015 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.20 Графикаас харахад Монгол Улсын ДНБ нэрлэсэн үнээр 3.5 дахин буюу 249.2 хувиар өссөн бол 2015 оны зэрэгцүүлсэн үнээр 40.0 хувиар өссөн байна. Энэ нь эдийн засгийн хэмжээ томорч байгаа ч инфляцийн нөлөөг тооцвол бодит өсөлт харьцангуй бага байгааг харуулж байна.

¹³ 28¹.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга үнэт цаас гаргах тухай саналаа ИТХ-д танилцуулах бөгөөд дэмжсэн шийдвэр гарсан тохиолдолд төсвийн жил эхлэхээс дөрөвөөс доошигүй сарын өмнө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулна.

¹⁴ 2024 оны 12 дугаар сарын 30 -ны өдөр 1 ам.доллар 3,420.25 төгрөгтэй, 2023 оны 12 дугаар сарын 30 -ны өдөр 1 ам.доллар 3,410.69 төгрөгтэй тэнцэж байна.

График 3. Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.21 ДНБ-ий бүтцийг салбараар нь авч үзэхэд 2022-2024 онд уул уурхай, олборлолтын салбар 23.0–28.1 хувийг эзэлж байгаа нь эдийн засаг уул уурхайн орлогоос өндөр хамааралтайг харуулж байна. Уул уурхай, олборлолтын салбарын дараагаар үйлчилгээний бусад үйл ажиллагаа болон бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбар дийлэнх буюу 10.4-еес 25.9 хувийг эзэлж байна. ДНБ-ий бүтцийн хэт төвлөрөл нь өрийн тогтвортой байдалд эрсдэл дагуулах хүчин зүйл болж болзошгүй байна.

1.22 Засгийн газар нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2¹⁵-т заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан батлуулах, жилийн төсвийн төслийг тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.3¹⁶-т заасны дагуу батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төлөвлөх үүрэгтэй байна.

1.23 Засгийн газраас өргөн мэдүүлж, 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр УИХ-аар батлагдаж, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр шинэчлэн баталсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026–2027 оны төсвийн төсөөллийн тухай” хуульд Засгийн газрын өрийг ДНБ-ий 45.0–55.0 хувьд барихаар тусгасан нь өрийн хязгаарыг ДНБ-ний өсөлтөөс хамаарч нэмэгдэх нөхцөлийг хязгаарласан зохицуулалт болжээ.

1.24 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төсвийн хүрээний мэдэгдлийг 15 удаа баталсан ч жил бүр өөрчлөлт оруулсан байна. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд байнга өөрчлөлт оруулж байгаа нь дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдол болон өрийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг бууруулах эрсдэлтэй тул төсвийн хүрээний мэдэгдлийг тогтвортой мөрдөх шаардлагатай байна.


Засгийн газраас 2023-2024 онд өрийн үйлчилгээний зардалд нийт 9,612.8 тэрбум төгрөг төлсөн байна

1.25 Засгийн газрын өрийн үйлчилгээний зардалд 2023 онд гадаад үнэт цаасны эргэн төлөлтэд 3,911.2 тэрбум төгрөг, гадаад зээлд 1,415.3 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасанд 881.0 тэрбум төгрөг нийт 6,207.5 тэрбум төгрөг, 2024 онд гадаад үнэт цаасанд 1,469.0 тэрбум төгрөг, гадаад зээлд 1,791.3 тэрбум төгрөг, дотоод үнэт цаас 145.0 тэрбум төгрөг нийт 3,405.3 тэрбум төгрөг тус тус төлсөн байна. Өрийн үйлчилгээний зардалд 2023-2024 онд нийт 9,612.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

¹⁵ Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

¹⁶ Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөөт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.

График 4. Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

1.26 Засгийн газрын өрийн үйлчилгээний хүүгийн төлбөрт 2023-2024 онд нийт 2,213.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Хүүгийн зардал 2023 онд 1,088.1 тэрбум төгрөг буюу нэгдсэн төсвийн урсгал зардлын 6.4 хувьтай байгаа нь 2022 онтой харьцуулахад 1.0 пунктээр нэмэгдсэн дүнтэй байна. Өрийн үйлчилгээнд 2023 онд төлсөн хүүгийн төлбөр боловсролын салбарт зарцуулах хөрөнгө оруулалтын төсвөөс 2.1 дахин их, эрүүл мэндийн салбарт зарцуулах хөрөнгө оруулалтаас 2023 онд 6.3 дахин их байсан байна.

1.27 Засгийн газраас 2025-2028 онд төлөх өрийн үйлчилгээний зардалд нийт 16,418.9 тэрбум төгрөг төлөхөөр байгаа бөгөөд гадаад өрийн эргэн төлөлтийн үндсэн төлбөрт 12,171.8 тэрбум төгрөг байгаа нь дахин санхүүжилтийн эрсдэл хэвээр байгааг, хүүгийн төлбөр 4,247.3 тэрбум төгрөг байгаа нь дунд хугацаанд төсөвт үргэлжлүүлэн ачаалал үзүүлэхээр байна.

Хүснэгт 6. Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал, тэрбум төгрөгээр

Засгийн газрын өрийн эргэн төлөлт	2025		2026		2027		2028	
	Үндсэн	Хүү	Үндсэн	Хүү	Үндсэн	Хүү	Үндсэн	Хүү
Дотоод өрийн нийт эргэн төлөлт	100.0	28.0	100.0	19.5	100.0	10.5	-	1.0
	128.0		119.5		110.5		1.0	
Гадаад өрийн нийт эргэн төлөлт	3,138.7	1,127.9	2,083.9	1,074.1	3,051.2	1,065.6	3,598.0	920.7
	4,266.6		3,158.0		4,116.8		4,518.7	
Засгийн газрын өрийн нийт эргэн төлөлт	3,238.7	1,155.9	2,183.9	1,093.6	3,151.2	1,076.1	3,598.0	921.7
	4,394.5		3,277.4		4,227.3		4,519.7	

Эх сурвалж: Сангийн яам

БҮЛЭГ 2. ӨРИЙН УДИРДЛАГЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ ХОЙШЛУУЛСАН Ч ДАХИН САНХҮҮЖИЛТ, ХАНШИЙН ЭРСДЭЛТЭЙ ХЭВЭЭР БАЙНА

Оршил

Энэ бүлэгт стратегийн зорилтууд, түүний хүрээнд хэрэгжүүлэх арга замыг тус бүрд авч үзэн биелэлт, анхаарвал зохих асуудлыг тодрууллаа.

Зорилт 1. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй, хөгжлийн бодлогод туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр гадаад зээл авч байгаа ч Өрийн удирдлагын тухай хуулийн зарчмуудыг баримтлах шаардлагатай байна

2.1 Засгийн газрын гадаад зээлийн хөренгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлж, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулах зорилтын хүрээнд 3 арга замыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

2.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹⁷ дэх хэсэгт 7 төрлийн зориулалтаар өр үүсгэж болно гэж зааснаас 12.1.1 дэх “Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх”, 12.1.5 дахь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх” заалтыг тус тус үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч ашиглаж байна.

2.3 Зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга замын 2-т Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6¹⁸-д заасан тухайн төслийг санхүүжүүлэх шийдвэрийг УИХ баталгаажуулснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглахаар заасан байна.

2.4 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратеги хэрэгжсэн 2023 онд 10, 2024 онд 11, нийт 21 гэрээ байгуулсан байна. Үүнд:

2023 онд:

- АУЭБЯ: БНЭУ-аас 1.0 тэрбум ам.долларын зээлийн эргэн төлөлтийн хуваарийг тодорхойлсон ЕРС-01, ЕРС-02, ЕРС-03 багц ажлын зээлийн гэрээ, 992.2 сая ам.доллар;**
- БХБЯ: БНАУ-аас Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөлд 7.5 сая евро;**
- ЗТЯ: ЕСБХБ -аас “Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ барих” төслийн зээлийн хэлэлцээрт нэмэлт санхүүжилтэд 20.0 сая ам.доллар, Дэлхийн банкнаас “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөлд 100.0 сая ам.доллар, 7.3 сая зээлжих тусгай эрх АХБ-аас Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалын төсөл (III үе шат) 150.0 сая ам.доллар;**
- ЦХХЯ болон ЗГХЭГ: Дэлхийн банкнаас Ухаалаг засаг-2 төсөлд 29.5 сая зээлжих тусгай эрх;**
- БСҮХ: АХБ-аас Хилийн үр бүтэээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөлд 95.0 сая ам.доллар;**
- НЗДТГ: ЕСБХБ-аас “Ногоон-Улаанбаатар орон сууц” төсөлд 20.0 сая ам.доллар;**
- Сангийн яам: АХБ-аас Төсөө, санхүү, эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөр - Дэд хөтөлбөр-1 төсөлд 100.0 сая ам.доллар;**
- ЭМЯ: БНАУ-аас АШУУИС болон эмнэлгүүдийн тоног төхөөрөмж шинэчлэх төсөлд 7.5 сая евро;**

¹⁷ 12.1. Засгийн газар дараах зориулалтаар өр үүсгэж болно:

12.1.1. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх.

12.1.2. төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх.

12.1.3. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих.

12.1.4. Өрийг дахин санхүүжүүлэх.

12.1.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх.

12.1.6. Улсын төлбөрийн тэнцилийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

12.1.7. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх

¹⁸ нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжүүлэх эсэхийг тухайн жилийн төсвийн хуулиар, шаардлагатай тохиолдолд тухай бүр шийдвэрлэх;

Аудитын код: ГНАГ-2025/03-ШТА-ГА

Хуудас | 18


2024 онд:

- ЭЗХЯ:** АХБ болон Уур амьсгалын ногоон сангаас Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 140.2 сая ам.доллар;
- Боловсролын яам:** АХБ-аас Эдийн засгийн хүндэрэлийн үед боловсролын чанарыг сайжруулах төсөл - Нэмэлт санхүүжилтэд 15.0 сая ам.доллар;
- ЭМЯ:** ЕСБХС-аас Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих төсөлд 43.2 сая ам.доллар, БНАУ-аас Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах төсөлд 10.0 сая ёвро, АХБ-аас Эмзэг булгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2-т 82.2 сая ам.доллар;
- ОБЕГ:** БНФУ-аас Онцгой байдлын ерөнхий газарт гол унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөлд 13.3 сая ёвро, Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангиid нэмэлт сургалт явуулах төсөлд 24.7 сая ёвро;
- ЭХЯ:** БНХАУ-аас Эрдэнэбурэнгийн УЦС барих төсөлд 253.1 сая ам.доллар;
- ЦХХХЯ:** БНХАУ-аас Харилцаа холбооны салбар чанарын хүртээмжийг сайжруулах төсөлд 20.9 сая ам.доллар;
- Сангийн яам:** АХБ-аас Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг /төсөийн дэмжлэг/ 100.0 сая ам.доллар,
- ХААХҮЯ:** АХБ-аас Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил 2 төсөлд 57.1 сая ам.долларын гэрээг тус тус байгуулсан байна.

2.5 Эдгээр 21 гэрээг байгуулж хэрэгжүүлэхээр эхэлсэн төсөл, арга хэмжээ Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д заасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байх шаардлагыг хангасан гэх боловч урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг боловсруулахад хууль тогтоомжид заасан чиг үүргээ ЭЗХЯ¹⁹ бүрэн хэрэгжүүлээгүй нь ҮАГ-аас 2025 онд хийсэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайландаа дурдагдсан байна.

2.6 Төсөл, арга хэмжээ санхүүжүүлэхээр 2023-2024 онд авч ашигласан 3,255.9 тэрбум төгрөгийн гадаад зээлийн ашиглалтыг салбараар авч үзвэл барилга, авто зам, дэд бүтцэд нийт ашиглалтын 42.4 хувийг зарцуулсан бол үйлдвэрлэлийн салбарт 18.7 хувийг зарцуулж байна. Стратегийн зорилтод туссан бодит эдийн засгийн салбарт шууд нөлөө үзүүлэх чиглэлээр гадаад зээлийг авч ашиглалтыг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

График 5. Гадаад зээлийн 2023-2024 оны ашиглалтын салбараар ангилсан үзүүлэлтүүд



Эх сурвалж: Сангийн яам, аудитын тооцоолол

2.7 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичигт заасан эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон бодит эдийн засгийн салбарт чиглээгүй гэсэн шалтгаанаар дараах 15 төслийг буцаасан байна. Үүнд,

- ЭХЯ:** Ухаалаг эрчим хүчиний системийг хөгжүүлэх төсөл, Улаанбаатар хотын цахилгаан түгээх сүлжээний үр ашигийг нэмэгдүүлэх, ухаалагжуулах төсөл, Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах хийн дулааны станцын төсөл, Төвийн бусийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашигийг дээшлүүлэх төсөл, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл, Төвийн бусийн нэгдсэн сүлжээнд ажиллах ус

¹⁹ ҮАГ-ын 2025 онд хийсэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт” аудитын тайлангийн 1.21-т ЭЗХЯ “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал”-д заасны дагуу7 ТЕЗ-дын ирүүлсэн үнэлээ, эрэмбийг харгалзан төслийг дээшлүүлэх төсөл, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл, Төвийн бусийн нэгдсэн сүлжээнд ажиллах ус

хуримтлуурт усан цахилгаан станц төсөл, 110/35/10 кВ-ын 2*40 МВА хүчин чадалтай "Их наран, "Баянхошуу", "Дамбадаржаа" дэд станц барих төслүүд;

- **ГХЯ:** Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн баригдах хот байгуулалтын дэд бүтцийн төсөл, Улаанбаатар хотын тойрог замын төсөл;
- **ХЭДХЯ:** Хууль зүй, дотоод хэргийн Яамны харьяа тусгай байгууллагуудын харилцаа, холбооны систем, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл;
- **ХХААХУЯ:** Ногоон, өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй төсөл, Мал, амьтны эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүнийг хадгалах, борлуулах цогцолбор төө, өвлүүн хүлэмж байгуулах;
- **БХБЯ:** Хөшгийн хөндийд байгуулагдах даван туулах чадавхтай, ногоон шинэ хотын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл;
- **НЭДТГ:** Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл 2;
- **ЭМЯ:** Яаралтай түргэн тусламжийн үндэсний тогтолцоог бий болгоход бусийн оношилгоо эмчилгээний төвүүдийг яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, агаарын түргэн тусламжийг хөгжүүлэх төсөл.

2.8 Мөн гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн хэмжээнд тооцогдох хүүгийн шимтгэл²⁰ 2023 онд 12.1, 2024 онд 39.4, нийт 51.5 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна. Иймд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх, ашиглагдаагүй зээлийн хэмжээг хязгаарлах, гадаад зээлийн гэрээ хэлэлцээр байгуулахаас өмнөх төслийн бэлтгэл ажлыг хангасан байх шаардлагатай байна.

2.9 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратеги хэрэгжсэн хугацаанд Өрийн удирдлагын тухай хуульд 2024 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрх олгосны дагуу НЭДТГ-аас дотоод болон гадаад бонд гаргаж, төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байна.

Хүснэгт 7. НЭДТГ-аас гаргасан үнэт цаасны мэдээлэл

№	Зориулалт	Гаргасан огноо	Эргэн төлөх огноо	Нэрлэсэн үлдэгдэл	
				Тэрбум төгрөг	
1	Зам засвар, арчилгаа	2024.06.25	2025.06.25	106.2	
2	Зам засвар, арчилгаа	2024.06.25	2026.06.25	106.8	
3	Бөөрөлжүүтийн ДЦС барих	2024.06.25	2027.06.25	321.9	
4	Батарей хуримтлуурын станц барих	2024.12.26	2029.12.26	298.4	
5	Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах	2024.11.29	2027.08.29	1,725.1	
				2,558.4	

Эх сурвалж: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлан

2.10 Богино хугацаатай /1-5 жил/, арилжааны нөхцөлтэй дотоодын зах зээлээс 798.0 тэрбум төгрөг, гадаад зах зээлээс 500.0 сая ам.долларын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр зам засвар, арчилгаа, Бөөрөлжүүтийн ДЦС барих, батарей хуримтлуурын станц барих, Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах зэрэг төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д энэ хуульд өөрөөр заагаагүй бол арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийн эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, 6.4.3-д тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа нь түүнийг санхүүжүүлэх зээллэгийн эргэн төлөх хугацаанаас илүүгүй байх чиглэл баримтлах, 6.4.4-д гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтлах гэсэн өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зарчмыг алдагдуулсан байна.

2.11 Энэ НЭДТГ-аас гаргасан бонд нь богино хугацаатай, хүү өндөртэй арилжааны нөхцөлтэй санхүүжилтийг урт хугацаанд хэрэгжүүлэх дэд бүтцийн төсөл, арга хэмжээнд авч ашиглах нь эдийн засгийн үр ашиггүй бөгөөд "Чингис", "Самурай" бондын МУХБ-аар дамжуулан гаргасан зарцуулалтаас үүссэн бодлогын алдааг давтах эрсдэлтэй байна.

2.12 Иймд шинээр боловсруулагдах Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт орон нутгийн зээллэг хийх дээд хэмжээг хязгаарлах шаардлагатай байна.

²⁰ Commitment fee

2.13 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд нийт гадаад зээлийн 24.1 хувь буюу 1,034.3 тэрбум төгрөгийг авч ашигласан байна. Харин төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй байна.

Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөөт дарамт учруулахгүйгээр дахин санхүүжилт хийж, зээлжих зэрэглэл ахисан байна

2.14 Засгийн газар өмнөх онуудад гаргасан гадаад үнэт цаасыг дахин үнэт цаас гаргах замаар санхүүжүүлэх, хугацаанаас өмнө буцаан худалдан авах зэрэг өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж, өрийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан байна. Тухайлбал,

- 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 650.0 сая ам.долларын 8.65 хувийн хуутэй “Сенчири-2” бондоор 2023 онд төлөгдөх “Гэрэгз” бонд, 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын тодорхой хэсгийг
- 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 350.0 сая ам.долларын 7.875 хувийн Сенчири-3” бондыг арилжаалж 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын тодорхой хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд тус тус шийдвэрлэсэн.
- 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 500.0 сая ам.долларын 6.625 хувийн хуутэй Сенчири-4 бондыг арилжаалж Номад бондын 391.7 сая, Сенчири-2 бондын 108.3 сая ам.долларыг төлсөн байна.
- Стратегийн хэрэгжилтийн хугацаанд “Гэрэгз” бондын үлдэгдэл 90.8 сая ам.долларыг, “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр болох 52.9 сая ам.долларын төлбөрийг тус тус Засгийн газрын мөнгөн хөрөнгийн эх үүсээрээр төлж барагдуулсан байна.


2.15 Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2022 онд 2,717.2 сая ам.доллар байсан бол 2024 онд 2,479.1 сая ам.доллар болж буурсан байна. Хэдийгээр төсөвт хүндэрэл үүсгэхгүйгээр өрийг дахин санхүүжүүлж, Монгол Улс өрийн дарамтын эрсдэлээс зайлсхийж чадсан зэрэг нөлөөтэй ч урт хугацаанд дахин санхүүжүүлэх хэрэгцээ хэвээр байна.

2.16 “Сэлбээ дэд төвийг орон сууцжуулах” зорилгоор НЗДТГ²¹-аас 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр гадаад зах зээлд 500.0 сая ам.долларын бонд гаргасан нь Стратегийн баримт бичигт²² дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байхаар заасантай нийцэхгүй байна.

2.17 Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханганд хамтарч ажиллахаар заасан байна. Энэ хүрээнд зээлжих зэрэглэл тогтоодог байгууллагуудтай уулзалт хийн, мэдээллээр ханганд, хамтран ажилласан байна.

2.18 Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Олон улсад зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас сүүлийн 10 жилд хөрхэн үнэлж байсныг харуулбал дараах байдалтай байна.

График 6. Гадаад үнэт цаасны үлдэгдлийн өөрчлөлт /хуриимтлагдсан хүү хасаж тооцсоноор/, сая ам.доллар



Эх сурвалж: Сангийн яам

²¹ Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д Монгол Улсын нэгдсэн төсөөв нь улсын төсөөв, орон нутгийн төсөөв, Ирээдүйн өө сангийн төсөөв, Үндэсний баялагийн сангийн төсөөв, Нийгмийн даатгалын сангийн төсөөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөөвөс бүрдэнэ.

21.2-д Орон нутгийн төсөөв нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн дээд шатны төсөөв нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсөөв байна.

²² Зорилт 2-ыг хэрэгжүүлэх арга зам 3-т

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 8. Дунд хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Үнэлгээ өгсөн байгууллага	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Фитч	B	B-	B-	B	B	B	B	B	B	B+
Мүүдис	B2	B3	Caa1	B3	B3	B3	B3	B3	B3	B2
Эс энд Пи	B	B-	B-	B	B	B	B	B	B	B+

Эх сурвалж: Сангийн яам

2.19 Стратегийн анхны баримт бичгийн хэрэгжилт эхэлсэн он буюу 2016 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Мүүдис агентлаг B2, хэтийн төлөвийг серөг, Фитч агентлаг B, хэтийн төлөвийг тогтвортой, Эс энд Пи агентлаг B+, хэтийн төлөвийг тогтвортой хэмээн үнэлж байсан байна.

2.20 Гэвч Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарсан, төсвийн алдагдал эрс нэмэгдсэн болон гадаад валютын нөөц багасаж, төгрөгийн ханш огцом суларсан, 2017 болон 2018 онд их хэмжээний гадаад бондын төлбөрийг төлөхөөр хүлээгдэж байсан зэргээс үүдэн дээрх 3 байгууллага Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2016 оны дунд үеэс бууруулж, өндөр эрсдэлтэй ангилалд оруулж байсан бол 2024 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Фитч агентлагаас “B+, тогтвортой”, Эс энд Пи агентлагаас “B+, эзэрэг”, Мүүдис агентлагаас “B2, тогтвортой” төлөвтэй болгож ахиулсан байна.

2.21 Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2024 оноос ахиулсан нь гадаадын хөрөнгө оруулагчдын Монгол Улсад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал арга хэмжээ болоод зогсохгүй аж ахуйн нэгж байгууллагуудын зээлжих зэрэглэл нэмэгдэх нөхцөл боломж бүрдэх бөгөөд олон улсын зах зээлд арилжаалагдаж буй Засгийн газрын үнэт цаасны үнэ өсөхөд өндөр ач холбогдолтой юм.

2.22 Стратегийн баримт бичгийн зорилтод Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхжүүлэх, мэдээллээр хангах арга хэмжээг тусгасны дагуу хөрөнгө оруулагчдын Монгол Улсад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор олон улсын уулзалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

2.23 Үүний үр дүнд зээлжих зэрэглэл нэмэгдсэн мэдээлэл, хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхжүүлсний дунд Засгийн газрын олон улсад гаргасан бондын өгөөж сайжирсан байна.

График 7. Засгийн газрын гаргасан гадаад бондын өгөөж, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

2.24 Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагаас 2023-2024 онд ирсэн тайлангуудыг харвал дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

- **Мүүдис:** Монгол Улсын зээлжих зэрэглэл 2023 онд В3 байсан бол 2024 онд В2 болж ахисан нь өрийн дарамт буурч, эдийн засаг тогтвортой өсөж, санхүүгийн бодлого хариуцлагатай хэрэгжиж буйтай холбоотой гэж дүгнээд гадаад өрийн өндөр түвшин, түүхий эдийн зах зээлийн хэлбэлзэл, төсвийн зардлын өсөлт зэрэг сорилтууд үргэлжилж байгаа тул эдийн засгийн удирдлагыг сайжруулж, тогтвортой байдлыг хадгалах нь чухал байгааг онцолсон байна. Санхүүгийн сахилга батыг хадгалах, өрийн удирдлагыг үргэлжлүүлэн сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийг хурдаасгах, гадаад валютын нөөцийг хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлбэл Монгол Улсын зээлжих зэрэглэл цаашид В1 эсвэл түүнээс дээш түвшинд өсөх боломжтой гэж дүгнэсэн байна.
- **Фитч:** Fitch агентлаг 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэлийг 'B+' болгон ахиулсан байна. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт, гадаад валютын нөөцийн нэмэгдэл, өрийн дарамтын бууралт зэрэг зерэг хүчин зүйлстэй холбоотой бол гадаад өрийн хэмжээ өндөр хэвээр, түүхий эдийн үнийн хэлбэлзэл өндөр, экспортын 90 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн тул дэлхийн зах зээлийн хэлбэлзэлд эмзэг, БНХАУ-ын эдийн засгийн удаашраглал нүүрсний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй, төсвийн бодлого тэлэлтийн шинжтэй хэвээр байгаа зэрэг нь эрсдэлтэй байна. Цаашид гадаад өрийн дарамт нэмэгдэж, төлбөрийн чадвар муудах, хөрөнгө оруулалт буурч, эдийн засгийн өсөлт удаашраглал, санхүүгийн сахилга бат алдагдаж, төсвийн алдагдал огцом нэмэгдэх зэрэг тохиолдолд зээлжих зэрэглэл буурахыг анхааруулсан байна.
- **Эс энд Pi:** Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 'B+' болгон ахиулсан бөгөөд төлөвийг зерэг гэж үнэлсэн байна. Энэ нь хурдтай эдийн засгийн өсөлт, уул уурхайн экспортоос орох орлого нэмэгдсэн зэрэг зерэг хүчин зүйлстэй холбоотой байна.

2.25 Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, төсвийн зарлагын тэлэлт, санхүүгийн сахилга бат, нийгэм эдийн засгийн тогтвортой байдал зэрэг үзүүлэлтүүдийг ажиглаж байгаа нь эдгээр тайлангаас харагдаж байгаа бөгөөд Монгол Улс бодлогын тогтвортой байдал, нийгэм эдийн засгийн тогтвортой өсөлтөө хадгалж чадвал зээлжих зэрэглэл үргэлжлэн сайжрах боломжтой байна.

Зорилт 3. Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор тодорхой ажлууд хийгдсэн ч гадаад зах зээлийн таагүй байдал, орон нутгийн өр төлбөрийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх шаардлагатай байна

2.26 Зорилт 3-ын хүрээнд 5 хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Үүнд:

Дүрслэл 2. Дунд хугацааны стратегийн зорилт 3-ын хүрээнд хийгдэх ажлууд

Хэрэгжүүлэх арга зам 1	Хэрэгжүүлэх арга зам 2	Хэрэгжүүлэх арга зам 3	Хэрэгжүүлэх арга зам 4	Хэрэгжүүлэх арга зам 5
1. Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанктын хамтран ажиллах, гадаад өрийн үйлчилгээний хувьарыг велиотын неавтойтой уялдуулж, шавьдлагатай тохиолдоод вэл болон хүйтнүүн свот халзанцээрийг зээлдүүлэгч талтвай хийх	2. Далхий нийтэд түүлгрэвд байгаа инфляцын өсвөлтөөс шалтгаалан гэдэвэд зах зээлд бий болоод бэлгэвчүүгүүн өсвөлтөөс хамаарсан урт, дунд хугацаанд Засгийн газрын гэдэвэд зээлийн хөвөгч хүү авхж болоход тогтолцоулж түүтэй зээл авхж нөхцөлийг зээлдүүлэгч талд тэвэж ажиллах	3. Тогтвортой хөгжлийн зорилтод нийцэн төсөл, арга хэмжээг дэмжихж, тэдэвэрийн санхүүжилтийг Тогтвортой хөгжлийн зорилтод нийцэн арийн хэрэгжлэлтэй уждуулж, Засгийн газрын өрийн зохицуулалтын арга хэмжээнд нэвтрүүлах боломжийг судалж, бэлтгэл ажлыг хөнгүүлэхэд холбогдох явамтей хамтран ажиллах, түүнчлэн здгэр арга хэмжээнийг вч холбогдлыг олон нийтэд таниулах	4. Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж мэдээллийн нэгдсэн санг шинчлэх нехцэлийг бурдуулж	5. Орон нутгийн засгэг захиргваны өрийн удирдлагын чадвакыг бэлжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтөлбөх талбар хэмтрен ажиллах.


Эх суреалж: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг

2.27 Зорилт 3-ын хэрэгжүүлэх арга зам 1-ийн хүрээнд 2023-2024 оны хугацаанд гадаад өр төлбөрийг бууруулах, боломжит хэмжээгээр мөнгөн хөрөнгөөс төлөх, ингэхдээ Монгол Улсын гадаад валютын албан нөөцтэй уялдуулах чиглэлээр дараах ажлыг хийсэн байна.

2.28 Монголбанктай хамтран Засгийн газрын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үнэ анх гаргасан үнээс бага байгаа үед буюу 2023 оны 10 дугаар сард "Номад" бондын төлбөрөөс 22.0 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг, 2024 оны 10-12 дугаар сард "Номад", "Сенчири-1" бондуудын төлбөрөөс 98.9 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг тус тус буцаан худалдан авсан бол "Гэрэгэ", "Хуралдай" бондын үлдэгдэл төлбөр болох 144.0 сая ам.долларын төлбөрийг улсын төсвөөс төлсөн байна.

2.29 Зорилт 3-ын хэрэгжүүлэх арга зам 2-ын хүрээнд дэлхий нийтэд тулгараад байгаа инфляц, гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс шалтгаалан урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүйтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах хүрээнд Засгийн газрын хувьд 2023-2024 оны хооронд нийт 2,448.7 сая ам.доллар, 63.0 сая евро, 36.8 сая ЗТЭ-тэй тэнцэх хэмжээний зээлийн гэрээ байгуулснаас 1,506.1 сая ам.доллар, 63.0 сая евро, 36.8 сая ЗТЭ зээлийг тогтмол хүйтэй нөхцөлөөр байгуулсан байна.

График 8. Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин, хувь, 2022-2025 он



Эх сурвалж: Сангиин яам

2.30 Гадаад зах зээлийн таагүй байдлаас²³ шалтгаалж Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн жишиг болгон авдаг баталгаат овернайт санхүүжилтийн түвшин (SOFR) өсж байна. Мөн Дэлхийн банкнаас улс орнуудыг орлогоор нь ангилсан ангиллаар Монгол Улс дунджаас дээгүүр орлогын ангилалд хамаарч Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээлдүүлэх зээлийн нөхцөл хөнгөлөлттэй нөхцөлөөс арилжааны нөхцөл рүү шилжиж байгааг стратегийн хэрэгжилтийн тайландаа тусгасан байна.

2.31 Энэ нь гадаад зээллэгийн хүүгийн түвшин өсөх, хугацаа богиносох нөхцөлийг бүрдүүлж, улмаар хүүгийн болон дахин санхүүжилтийн эрсдэл нэмэгдэхэд нөлөөлөхөөр байна. Иймд шинээр боловсруулж, батлах 2026-2028 оны стратегийн баримт бичигт эдгээр нөхцөлүүдийг харгалзаж үзэх нь зүйтэй байна.

2.32 Сангиин яамнаас ирүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайландаа Зорилт 3-ын хэрэгжүүлэх арга зам 3-ын хүрээнд ТХЗ-д нийцсэн төсөл, арга хэмжээг дэмжиж, тэдгээрийн санхүүжилтийг ТХЗ-д нийцсэн өрийн хэрэгсэлтэй уялдуулж, Засгийн газрын өрийн зохицуулалтын арга хэмжээнд нэвтрүүлэх боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангуулахад холбогдох яамтай хамтран ажиллах, түүнчлэн эдгээр арга хэмжээний ач холбогдлыг олон нийтэд таниулах гэсэн ажлын

²³ Олон улсын эдийн засаг 2020 оноос хойш КОВИД-19 цар тахал, геополитикийн мергелдөөн буюу ОХУ болон Украинаын хурцад мал байдал, дундад азиid гарч буй мөргөлдөөн болон дэлхий нийтэд тулгараад буй инфляцийн өсөлт эзрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж хөгжингүй орнууд бодлогын хүүгийн түвшинээ өсгөж эхэлсэн.

хүрээнд нийт ТХЗ-д нийцсэн бондын баримт бичгийг боловсруулж Эс энд Пи агентлагаар үнэлгээ хийлгэсэн байна. Дүгнэлтэд,

- Монгол Улсын ТХЗ-д нийцсэн өрийн хэрэгслээр санхүүжигдэх боломжтой төслүүдийн жагсаалтад байгаль орчин болон нийгмийн үр өгөөж харьцаангуй бага байж болзошгүй зарим төслийн төрөл багтсан байна.
- Зарим нийгмийн төслийн шалгуур үзүүлэлтийг хэмт ерөнхий байдлаар тодорхойлсон байгаа нь Монгол Улсын тогтвортой санхүүжилт авах боломжийг хязгаарлах эрсдэлтэйг анхааруулсан байна.

2.33 Зорилт 3-ын хэрэгжүүлэх арга зам 4-ийн хүрээнд Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэхээр тусгаж DMFAS²⁴-ийн нэмэлт хөгжүүлэлт болох Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний дэд систем DMS-ийг боловсруулсан байна.

2.34 Зорилт 3-ын хэрэгжүүлэх арга зам 5-ын хүрээнд НЗДТГ-аас 2024 онд 798.0 тэрбум төгрөгийн дотоод, 500 сая ам.долларын гадаад үнэт цаас гаргасан ажилд Сангийн яамны зүгээс хамтран ажилласан гэж тайлагнасан байна. Энэ хэрэгжүүлэх арга замын гол агуулга болох болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэхээр тодорхойлогдсон байхад эдгээр гаргасан үнэт цаас хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

- Сэлбэ дэд төв²⁵: Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хэрхэн бүрдүүлэх талаар нарийвчилсан тооцоо судалгааг бодитой хийгээгүй байна. Үнэт цаасны эргэн төлөлтийг Сэлбэ дэд төвийн хүрээнд нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдах 7,328 айлын орон сууцаар 5-н буудал, Хайлааст, Чингэлтэй, ойр орчмын 640 га газрыг сольж чөлөөлснөөр 1 га газрыг 4.0 тэрбум төгрөгөөр худалдан борлуулснаар 2,622.1 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой гэж үзсэн. Орон сууцны төв зам дагуу 7,328 айлын орон сууцны үйлчилгээний зориулалтын 100.0 мянган м.кв талбайг 548.2 тэрбум төгрөгөөр, 9-20 хувийн дээш налуутай тохиromжгүй үнэлгээтий орон сууцыг 3.7 тэрбум төгрөгөөр, нийт 551.9 тэрбум төгрөгийн орлого олохоор тооцсон боловч ТЭЗҮ-ээс өөр нарийвчлан тооцсон тооцоо судалгаа байхгүй;
- Дотоодод гаргасан зам засвар, арчилгаанд зарцуулах 200.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны транч-1 нь 1 жилийн хугацаатай 15.0 хувийн хүүтэй 100.0 тэрбум, транч-2 нь 2 жилийн хугацаатай 15.0 хувийн хүүтэй 100.0 тэрбум төгрөг бөгөөд 2025-2026 онд эргэн төлнэ.
- Гэвч буцаан төлөх эх үүсвэрийг авто зам ашигласны төлбөрийг 5 дахин, АТБӨЯХ-ийн албан татварын орлогын 1-3 дахин нэмэгдүүлэх замаар өрийн хүүгийн болон үндсэн төлбөрийг төлөхөөр тусгасан байна.²⁶

Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих үнэт цаасны арилжаа 2023-2024 онд хийгдээгүй байна

2.35 Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтээ технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх хүрээнд 2023 оноос Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны систем болох "bond.mse.mn" системийг Монголын Хөрөнгийн биржтэй хамтран хөгжүүлж, арилжааны банкнууд болон үнэт цаасны компаниудтай хамтран туршилтыг хийж байна.

2.36 Тус систем нь үнэт цаасны эргэн төлөлтийг бодож хөрөнгө оруулагчдад хүргүүлэх тул эргэн төлөлтэд зөрүү үүсэх эрсдэлийг бууруулсан бөгөөд 2017 он хүртэл ашигласан системээс дараах давуу талуудтай. Үүнд:

- Арилжааны мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Монголын Хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулагчидтай хуваалцах үйлдлийг автоматаар бууруулж;
- Арилжаа бүрийн мэдээллийг авах;
- Хураангуй тайланг цаг алдалгүй харах;
- Төлбөрийн тооцооллыг нэгдсэн байдлаар харах;
- Үнэт цаасны хуваарилалтыг автоматаар хийх зэрэг боломжтой болсон.

²⁴ НҮБ-аас хөгжүүлдэг "Өрийн удирдлагын болон санхүүгийн шинжилгээний систем"

²⁵ Эх сурвалж: УАГ-аас 2024 оны 6 дугаар сард гарсан дүгнэлт

²⁶ НИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/28, 24/29 дугаар тогтоолууд

2.37 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжаа зохион байгуулагдахаас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулахаар заасан ч Засгийн газраас дотоод бонд гаргах нөхцөл үүсээгүй шалтгаанаар 2023-2024 онд дотоод үнэт цаас гаргаагүй байна.

2.38 Харин Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг эхлүүлэхээр Сангийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 51 дүгээр тушаал гарч, дотоод үнэт цаас гаргах хуваарийг баталсан байна. Ингэж дотоод үнэт цаасны арилжаа эхэлсэн тохиолдолд стратегийн хэрэгжилт 2025 онд дуусах үед уг зорилт хэрэгжих боломжтой байна.

Хүснэгт 9. Хадгаламж болон хадгаламжийн хүүгийн өсөлт

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Хадгаламжийн үлдэгдэл, тэрбум төгрөг	15,284.3	16,492.5	15,272.5	17,881.1	22,131.5
Шинээр татсан хадгаламжийн төгрөгийн жилийн хүү, хувь	8.4	5.8	10.9	11.6	11.9

Эх сурвалж: <https://stat.mongolbank.mn/finance>

2.39 Хадгаламжийн хэмжээ өсөж байгаа нь дотоод санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах, гадаад өрийн дарамтыг багасгах боломжийг бүрдүүлнэ. Гэвч хадгаламжийн хүү өндөр байгаа нь дотоод үнэт цаасны өгөөжийг бууруулах тул боломжит эрсдэлийн түвшинд дотоод үнэт цаас гаргалтыг тогтмолжуулж, дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх нь зүйтэй байна.

Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслийн төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан ч хувийн хэвшлийн компаниуд хүсэлт ирүүлээгүйгээс тэдэнд дэмжлэг үзүүлэх өрийн баталгаа гаралаагүй байна

2.40 Монгол Улсын Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт БНХАУ-ын хөгжлийн банкнаас тавьсан шаардлагыг хангаагүйгээс шалтгаалан²⁷ Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгэх төслийн санхүүжилт болох 420.0 сая юанийн зээлийг зөвхөн Засгийн газрын өрийн баталгаатайгаар үргэлжлүүлэн олгох боломжтойг мэдэгдсэнд дагуу УИХ-ын 2023 оны Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай 90 дүгээр тогтоолоор МУХБ-ны 70.0 сая ам.долларын зээлээр хэрэгжиж буй дээрх төсөлд 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр өрийн баталгаа гаргасан байна.

2.41 Энэ төсөл нь УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлберийн 2.1.2-т заасан төсөл, арга хэмжээ бөгөөд стратегийн баримт бичгийн зорилтой нийцэж байна.

2.42 Улсын стратегийн томоохон төслийн төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан ч хувийн хэвшлийн компаниуд хүсэлт ирүүлээгүйгээс тэдэнд дэмжлэг үзүүлэх өрийн баталгаа гаралаагүй байна.

2.43 Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлберийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн тайлант хугацаанд МУХБ нь өөрийн хөрөнгөөр 30.0 тэрбум иенийн хэмжээтэй "Самурай" бондын төлбөрийг хугацаанд нь, Эрдэнэс Монгол ХХК-аас Азийн хөгжлийн банкнаас авч ашигласан Засгийн газрын өрийн баталгаатай зээлийн үлдэгдэл 8.6 сая ам.долларын төлбөрийг хугацаанаас өмнө буюу 2024 оны 10 дугаар сард эргэн төлж 2031 онд дуусах нөхцөлтэй зээлийг төлж барагдуулсан байна.

2.44 Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байхаар заасан бөгөөд Засгийн газраас

²⁷ Эх сурвалж: Сангийн яам

стратегийн тайлангийн хэрэгжилтийн хугацаанд шинээр барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ байгуулаагүй бөгөөд шинээр өрийн бичиг /вексель/ гаргаагүй байна.

2.45 Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг зөвхөн Засгийн газрын баталгаатай зээлээр шийдэх нь төсвийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэл үүсгэж болзошгүй тул төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх нь илүү оновчтой шийдэл байхаар байна.

Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулсан ч мэдээллийг нэг нэгдсэн стандартаар гаргах шаардлагатай байна

2.46 Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж хөтөлнө. гэж заасан байна. Тус мэдээллийн сан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-д заасны дагуу дараах мэдээлгүүдийг төвлөрүүлэн бүртгэхээр заажээ. Үүнд:

- Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдэл;
- Засгийн газрын үнэт цаасны арилжааны талаарх мэдээлэл, хуваарь;
- Засгийн газрын гадаад зээллэг, тэдгээрийн ашиглалт, гүйцэтгэл, дамжуулан зээлдүүлсэн зээл;
- Дэд болон эцсийн зээлдэгч, Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчийн төлбөрийн чадварын байдал, холбогдох гэрээний хэрэгжилт;
- Засгийн газрын өрийн баталгаа болон зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл.
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.2-т заасан Засгийн газрын зээл болон баталгаа;
- Болзошгүй өр төлбөрийн мэдээлэл;
- Аймаг, нийслэлийн өрийн мэдээлэл;
- Засгийн газрын тусгай сангуудын өрийн мэдээлэл;
- Төрийн болон орон нутгийн өмчт, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр;
- Бусад мэдээлэл.

2.47 Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний DMFAS системийг Сангийн яам 2001 оноос эхлэн өрийн удирдлагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн ба 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 9 удаагийн өөрчлөлт, шинэчлэлт хийсэн байна. Тус системд Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасан мэдээллүүдээс Засгийн газрын өр, Засгийн газрын гадаад зээллэг, тэдгээрийн ашиглалт, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг бүртгэн тайлагнаж байна.

2.48 Харин Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл, Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчийн төлбөрийн чадварын байдал, холбогдох гэрээний хэрэгжилтийг бүртгэж оруулах боломжтой хэдий ч НЗДТГ-ын өрийн удирдлагын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байгаатай холбоотойгоор бүртгэлд Сангийн яамнаас оруулж, бүртгэж байна.

2.49 Засгийн газрын үнэт цаасны арилжааны талаарх мэдээлэл, хуваарийг бүртгэж оруулах боломжтой ч 2017 оноос хойш Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалаагүйтэй холбоотойгоор аудитын хамрах хугацаанд бүртгэх мэдээлэл байхгүй байна.

2.50 Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем (ODAMIS) системийг 2020 оноос эхлэн нэвтрүүлсэн ба Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын дагуу зохицуулагдаж байна. Тус системд гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг бүртгэж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2-д заасны дагуу улирал тутам мэдээлж байна.

2.51 Гэвч гадаад зээлийн ашиглалтад 2023 онд 3, 2024 онд 11 төсөл, арга хэмжээний гадаад тусламжийн ашиглалтын мэдээллийг хамтад нь бүртгэсэн байна. Зээл, тусламжийн

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

мэдээллийг нэгтгэн тайлагнах нь нийт зээл, тусlamжийн ашиглалтын дүн мэдээ зөрүүтэй гарах, мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчим алдагдах эрсдэлтэй байна. Иймд Шилэн дансны тухай хууль болон холбогдох хуулийн зүйл, заалтыг тодорхой болгож, гадаад зээл, тусlamжийн тайлагналыг тусад нь мэдээлэх зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.52 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өрийг бүртгэх DMS системийг хөгжүүлсэн байна. DMS систем нь DMFAS системийн дэд систем бөгөөд төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэж улсын секторын өрийн бүртгэлийг хийж байна. Нийт 78 төрийн өмчит компани 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус системд бүртгэлтэй байна.

2.53 Болзошгүй өр төлбөрийн²⁸ нэг хэсэг болох Засгийн газрын өрийн баталгааны мэдээллийг DMFAS системд бүртгэж байгаа хэдий ч үндэсний аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөөс хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбогдон төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг мөнгөн дүнгээр бүртгэсэн бүртгэл байхгүй байна. Харин аймаг, нийслэлийн өрийн мэдээллийг улирал бүр Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан бичгээр авч DMFAS системд тухай бүр бүртгэж байна.

2.54 Сангийн яам засгийн газрын өрийн мэдээллийн бүллэгтэй улирал бүр нэгтгэн, цахим хуудсаараа олон нийтэд түгээдэг. YCX өрийн мэдээллийг тайлагнадаг ч хоёр байгууллагын гаргасан мэдээлэл зөрүүтэй байна. Энэ нь Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, түүний дотор өрийн үлдэгдэл аудитаар баталгаажиж Сангийн яамны тоон мэдээлэл эцэслэх үед YCX шинэчлэл хийдэггүй, мэдээллийг өөр бүтэцтэй гаргадаг зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Засгийн газрын өрийн мэдээллийн зөрүүтэй байдал

Үзүүлэлт	2023-IV			2024-IV		
	YCX	СЯ	Зөрүү	YCX	СЯ	Зөрүү
Засгийн газрын нийт өр	30,765.0	30,773.5	8.5	33,429.8	33,429.7	(0.1)
Засгийн газрын дотоод өр	234.1	234.1	-	1,233.8	400.5	(833.3)
Засгийн газрын гадаад өр	30,319.5	30,273.4	(46.1)	32,018.0	30,292.9	(1,725.1)
Засгийн газрын өрийн баталгаа	30.9	29.5	(1.4)	178.0	177.9	(0.1)
Барих-шилжүүлэх төрлийн концесс	180.5	236.5	56.0	-	-	-
Орон нутгийн зээллэг*	-	-	-	-	2,558.4	2,558.4

Эх сурвалж: YCX, Сангийн яам

2.55 Иймд зөрүүг арилгахын тулд Сангийн яам болон YCX мэдээллээ уялдуулж, нэг стандартаар боловсруулах шаардлагатай байна. Сангийн яам нь эцэслэсэн тоон мэдээллийг тухай бүр YCX хүргүүлж, статистикийн мэдээллийн нэгдсэн санд дахь тухайн мэдээллийг шинэчилж, нийцүүлэх ажлыг хамтран зохион байгуулах нь зүйтэй байна.

2.56 Олон нийт, судлаачдад илүү ойлгомжтой, харьцуулж болохуйц байдлаар мэдээллийг түгээх, нэгдсэн мэдээллийн сан бий болгосноор өрийн мэдээлэл илүү найдвартай, ил тод болох нөхцөл бүрдэх юм.

Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтын ханшийн эрсдэлийн зорилт хангагдаагүй байна

2.57 Стратегийн баримт бичигт туссан зорилтуудыг хэрэгжүүлснээр өрийн багцын үзүүлэлт дараах байдалтай болно гэсэн төсөөллийн гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 11. Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээний үр дүн

Өрийн зардал	Жигнэсэн дундаж хүү (хувь)	Түвшин	2023	2024	2025
			Дээд	3.8	4.3
		Гүйцэтгэл	3.5	4.2	

²⁸ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.48 “болзошгүй өр төлбөр” гэж Засгийн газрын гаргасан баталгааг хангах, эсхүл үндэсний аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөөс хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбогdon төсөвт үүсч болзошгүй эрсдэлийг мөнгөн дүнгээр тооцож илрэхийлснийг гэж заасан байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

Дахин санхүүжилтийн эрсдэл	Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	Доод	7.8	7.3	6.8
Хүүгийн эрсдэл	Засгийн газрын өрийн хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/	Гүйцэтгэл	7.9	7.6	
Ханшийн эрсдэл	Гадаад валютаар илэрхийлсэн өр /нийт өрдээ зэлэх хувь/	Доод	7.0	6.5	6.3
		Гүйцэтгэл	7.1	6.5	

Эх сурвалж: Сангийн яам

➤ **Өрийн зардал:**

2.58 Стратегийн хэрэгжилтийн хугацаанд буюу 2023-2024 онд хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр төсвийн алдагдал болон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн бөгөөд Засгийн газрын өрийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2023 онд 3.5 хувь, 2024 онд 4.2 хувийн гүйцэтгэлтэй гарч дээд түвшинд хүрээгүй байна.

2.59 Гэвч гадаад зээлийн жишиг хүү болох Баталгаат овернайт хүүгийн түвшний өсөлт нь гадаад зээлийн дундаж хүүгийн түвшнийг өсгөх, АНУ-ын Холбооны нөөц банкны бондын өгөөж өсөж байгаагаас цаашид хүүгийн түвшин өсөх эрсдэлтэй байна.

➤ **Дахин санхүүжилтийн эрсдэл:**

2.60 Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөгдөх дундаж хугацаа сүүлийн 6 жилийн байдлаар буурч байна. Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 2023 онд 7.9 жилтэй тэнцэж байсан бол 2024 онд 7.6 жилтэй тэнцэж буурсан бол 2025 онд буурах төсөөлөлтэй байна.

2.61 Энэ нь дэлхийн банкны улс орнуудыг орлогын түвшнээр ангилдаг аргачлалаар Монгол Улс²⁹ дундаас дээш түвшинд ирж олон улсын санхүүгийн байгууллагууд хугацаа өндөр буюу 30-40 жилийн хугацаатайгаар олгодог байсан зээлийг 10-25 жилийн хугацаатай олгож эхэлсэн³⁰, Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт улсын төсвийн хязгаараас шалтгаалж багаар санхүүжигдэж байгаатай холбоотой байна.


➤ **Хүүгийн эрсдэл**

2.62 Олон Улсын байгууллагуудаас тогтмол хүйтэй санхүүжилтийн эх үүсвэрийг хөвөгч хүйтэй эх үүсвэрт шилжүүлснээс шалтгаалиж³¹ гадаад зээлийн ашиглалтын 24.5 хувийг хөвөгч хүйтэй зээл эзэлж байна. Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа 2023 онд 7.1 жил, 2024 онд 6.5 жил болж буурсан бол 2025 онд 6.3 жил болж буурах төсөөлөлтэй байна. Энэ нь хүүгийн эрсдэлийг нэмэгдүүлснээр өрийн үйлчилгээний хүүгийн зардлыг өсгөж төсөвт ирэх ачааллыг нэмэх эрсдэлтэй, харин эсрэгээрээ хүүгийн түвшин буурвал, төсөвт үзүүлэх ачаалал буурах нөхцөл бүрдэх юм.

➤ **Ханшийн эрсдэл**

2.63 Гадаад валютаар илэрхийлсэн өрийн Засгийн газрын нийт өрдээ зэлэх хувь 2023 онд 98.4 хувь, 2024 онд 98.7 хувьтай тэнцэж зорилтот түвшин 80.0 хувиас хэтэрсэн үзүүлэлттэй байна.

График 9. Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/



Эх сурвалж: Сангийн яам

²⁹ Дэлхийн банкны тооцооллоор нэг хүнд ногдох УНБ 2022 онд 4,993.5 ам.доллар, 2023 онд 5,838.6 ам.доллар байна. Эх сурвалж: <https://wits.worldbank.org/CountryProfile/en/Country/BY-COUNTRY/StartYear/2015/EndYear/2023/Indicator/NY-GDP-PCAP-CD>

³⁰ Эх сурвалж: Сангийн яам

³¹ Монгол Улс дундаас дээш орлоготой орны ангилалд шилжсэнтэй холбоотой.

2.64 Энэ нь шинээр ашиглалт гарсан төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээллэгүүд гадаад валютаар илэрхийлэгдсэн, Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2017 оноос эхлэн арилжаалаагүйтэй холбоотой байна.

2.65 Ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан өсөж байгаа өрийг санхүүгийн үүсмэл хэрэгслийн тусламжтайгаар удирдах боломжийг ашиглах нь зүйтэй байна.

2.66 Засгийн газрын өрийн багцад хийсэн зардал, эрсдэлийн шинжилгээнд НЭДТГ-аас гаргасан гадаад, дотоод бондын нөлөөллийг оруулж тооцвол жигнэсэн дундаж хүү, 0.4 пунктээр, дахин санхүүжилтийн эрсдэл 0.3 пунктээр, хүүгийн эрсдэл 0.2 пунктээр, ханшийн эрсдэл 1.5 пунктээр тус тус нэмэгдэж, өрийн зардал, хүүгийн эрсдэл, ханшийн эрсдэлийн зорилтот түвшнийг давж байна.

Хүснэгт 12. Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээний үр дүн, НЭДТГ-аас гаргасан бондын нөлөөг тооцсоноор

Үзүүлэлт	Шалгуур	НЭДТГ-аас 2024 онд гаргасан бондын		
		нөлөөллийг оруулснаар	нөлөөллийг оруулаагүйгээр	
Өрийн зардал	Жигнэсэн дундаж хүү (хувь)	Дээд 4.3	4.6	4.2
Дахин санхүүжилтийн эрсдэл	Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	Доод 7.3	7.3	7.6
Хүүгийн эрсдэл	Засгийн газрын өрийн хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/	Доод 6.5	6.3	6.5
Ханшийн эрсдэл	Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр /нийт өрд зэлэх хувь/	Дээд 80.0	97.2	98.7

Эх сурвалж: Сангийн яам

2.67 Өрийн удирдлагын стратеги хэрэгжих байх үед Засгийн газрын өрийн багцын зардал эрсдэлийн шинжилгээний үр дүнгийн нөлөөллийг тооцохгүйгээр Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа нь Засгийн газрын өрийн бодит эрсдэлийг нэмэгдүүлж байна.

2.68 Иймд өрийн удирдлагын бодлого, төлөвлөлт, эрсдэлийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд НЭДТГ-аас гаргасан бондын нөлөөллийг оруулан тооцох шаардлагатай бөгөөд цаашид аймаг, нийслэлээс гаргах бондыг эргэн төлөлт хийх орлогын бодит хэмжээтэй уялдуулж, төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү асуудлыг онцгойлон анхаарч, холбогдох зохицуулалтыг хийх нь зүйтэй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯМ

Засгийн газрын II байр, С.Данзанчойн гудамж 2/1,
4-р хороо, Чингисийн дүүрг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-61) 26 74 68, Цахим шуудан: info@moi.gov.mn,
Цахим хуудас: <http://www.moi.gov.mn>

2025. 03.28 № 02/2214

тамай _____ -ны № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Я.САМБУУНЯМ
ТАНАА**

Танаас ирүүлсэн Засгийн газрын өрийн
удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт
бичгийн хэрэгжилтийн тайландаа орсон аудитын
тайлангийн тэсэлтэй танилцлаа.

Аудитын тайландаа хүргүүлэх саналыг
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудас.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Ж.ГАНБАТ

9765000371

Сангийн яамны 2025 оны 03 дугаар сарын 4^т-ны өдрийн
02/22/2025 тоот албан бичгийн хөвсрэлт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН
БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ОРСОН АУДИТЫН ТАЙЛАНД
егех санал**

Аудитын тайланд өгөх санал:

1.15. Сангийн сайдын тушаалаар шинэчлэн баталсан Өрийн удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16¹, 18, 16¹, 25, Өрийн удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т заасантай нийцэхгүй, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус байх зарчмыг алдаадуулж байна.

Санал: Өрийн удирдлагын зөвлөлийн гишүүн нь орон тооны бус байх бөгөөд ямар нэг байдлаар цалин, урамшуулалт авдаггүй болно. Иймд энэхүү зөвлөлд орж ажилласнаар хараат бус байдал алдагдахааргүй байна. Өрийн удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аюулгүй зөвлөлийн төлөөллөөс гадна санхүү, эдийн засгийн салбарын мэргэшсэн судлаачдын төлөөллийг Өрийн удирдлагын зөвлөлд оролцуулахаар тусгасан. Үүний дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тус шаардлагыг хангасан төлөөллийг оролцуулах нь Засгийн газрын өрийн дунд хугацааны стратеги, бодлого, өрийн зохицуулалтын үйл ажиллагаа болон тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэл зэргийн тогтмол мэдээлэл өгч, зөвлөмж өгөх боломжоор хангах өч холбогдолтой.

Тайлбар 1-ийг харна уу.

2.15 "Сэлбэ дэд төвийг орон сууцкуулах" зорилгоор НЭДТГ-аас 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр гадаад зах зээлд 500.0 сая ам.долларын бонд гаргасан нь Стратегийн баримт бичигт дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байхаар заасантай нийцэхгүй байна.

Санал: Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.19, 4.1.24 дэх заалтуудад Засгийн газрын үнэт цаас болон аймаг, нийслэлийн үнэт цаасыг тусдаа тодорхойлсон байх бөгөөд мөн хуулийн 12.1 болон 28¹.1 дэх хэсэгт Засгийн газрын үнэт цаас гаргах, аймаг нийслэлийн үнэт цаас гаргах зориулалт тусдаа зохицуулагдсан байна. Иймд аймаг, нийслэлийн үнэт цаас арилжаалж тесэл, хетэлбэр хэрэгжүүлэх нь Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасан шаардлагыг зөрчихөөргүй байна.

Тайлбар 2-ыг харна уу.

2.32 Засгийн газрын өрийн удирдлагын 2023–2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланд Зорилт 3-ын хэрэгжүүлэх арга зам 3-ын хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсөл, арга хэмжээг дэмжих, санхүүжилтийг уялдуулах чиглэлээр хийх ажлуудыг тусгасан болооч, нийт зээлзэгийн хэдэн хувь нь ТХЗ-д нийцсэн төсөл, арга хэмжээнд зарцуулагдсан талаар мэдээлэл тусгагдаагүй байна.

Санал: Стратегийн баримт бичигт ТХЗ-д уялдсан санхүүжилтийг авч ашиглааар бус судалж, бэлтгэл ажлыг хангах талаар тусгасан болно. Энэ хүрээнд ТХЗ-д нийцсэн бондын баримт бичгийг боловсруулж олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Эс энд Ги байгууллагаар дүгнэлт гаргуулсан болохыг тайлагнасан болно.

Тайлбар 3-ыг харна уу.

Түүнчлэн, ТХЗ-д нийцсэн бонд гаргах нь Засгийн газрын өрийн удирдлагын 2023–2025 оны стратегийн баримт бичигт нийцэхгүй бөгөөд урт хугацаанд гаргах шаардлага үүссэн тохиолдолд бэлэн байдлыг хангаж ажилласан болно.

2.36 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу аршжааг зохион байгуулагдахаас З сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулахаар заасан ч Засгийн газраас дотоод бонд гаргах нөхцөл үүсээгүй шалтгаанаар дотоод үнэт цаас гаргаагүй байна.

Санал: Засгийн газраас дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулах зорилгоор шаардлагатай бэлтгэл ажил болох арилжааны системийг хөгжүүлж, тус системийн туршилтыг тухай бүр мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон зах зээлд оролцогчидтой хийж байгааг бөгөөд 2025 онд эхлүүлэхээр дотоод үнэт цаасны арилжааны хуваарийг батлуулж ажиллаж байна.

Тайлбар 4-ийг харна уу.

Түүнчлэн, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаа дуусаагүй байгаа бөгөөд 2025 онд дотоод үнэт цаасыг арилжааны хуваарийн дагуу тогтмол арилжаалах телөвлөгөөтэй байна. Ингэснээр стратегийн хэрэгжилтийн хугацаанд тус зорилтыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

2.51 Сангиийн яам засгийн газрын өрийн мэдээллийн бюллитенийг улирал тутам нэгтгэж, олон нийтэд цахим хуудсаараа дамжуулан мэдээлдэг хэдий ч тус бюллитенийн тоон мэдээллийг баталгаажуулдаггүй, тайллагналын хэлбэр агуулгын хувьд харилцан адилгүй байна.

2.52 Энэ нь тухайн мэдээллийг хэрэглэдэг судлаачид, оюутнууд зэрэг иргэд олон нийтэд судалгаа, дун шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдал үүсгэж байна.

Санал: Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг Сангийн яамнаас улирал бүр цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Энэхүү товхимолд Засгийн газрын өрийн үлдэгдэл, өрийн үйлчилгээний гүйцэтгэл болон хуваарь өрийн багцын үзүүлэлтүүд, мөн төрийн емчit компанийн өр төлбөр зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүд багтдаг тул оюутан судлаачид авч ашиглахад тохиromжтой бөгөөд Сангийн яамны зүгээс товхимолыг тогтмол сайжруулахад анхаарч ажиллаж байна. Тус товхимолд жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл тайлагнагджад жилийн эцсийн гүйцэтгэл гарсан үед дахин шинэчилдэг. Харин энэхүү тоон мэдээлэл нь Үндэсний статистикийн хороонд улирал тутам тогтсон хугацаанд хүргүүлдэг бөгөөд дахин шинэчилдэгтүй тул жилийн эцсийн гүйцэтгэл болон урьдчилсан гүйцэтгэлийн мэдээллүүд зарим үед зөрөх тохиолдол гардаг болно.

2.63 Энэхүү нэлөөллийг тооцоогүй орхисон нь Засгийн газрын өрийн бодит эрсдэлийг бүрэн илрхийлээгүй харуулж байна

Санал: Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-т зардал-эрсдэлийн үзүүлэлтийг тооцоходоо баталгаа, концессыг тусгaaгүй гэж тусгасан бөгөөд тухайн үед орон нутгийн зээллэг авах төлөвлөгөө байхгүй байсан тул энэхүү хэрэгслийд нь зардал. эрсдэлийн тооцоолол болон төсөөлөлд ороогүй болно. Харин энэхүү орон нутгийн өр болон Засгийн газрын өрийн баталгаа гаргах хүсэлт ирсэн тохиолдолд Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтэд хэрхэн нэлөөлөх талаар тооцооллыг тухай бүр хийж ажиллаж байна.

Хэрэв Засгийн газрын өрийн удирдлагын тайлагнахдаа тус тооцооллыг оруулах нь стратегийн баримт бичиг болон хэрэгжилтийн тайлантгийн хооронд тооцооплын зоруу үүсгэхээр байна. Иймд хэрэгжилтийн тайланд тайлагнахдаа батлагдсан стратегийн баримт бичигт туссан тооцооплоор тусгасан болно.

Аудитын дүгнэлтэд өгөх тайлбар:

13. Сангийн яамнаас стратегийн баримт бичигт туссан зорилтуудыг хэрэгжүүлснээр өрийн багцын үзүүлэлтээс 2023-2024 онд өрийн зардал, дахин санхүүжилтийн эрсдэл, хүүгийн эрсдэлийн дээд, доод хязгаараас даваагүй ч гадаад вэлиятаар илрхийлсэн өрийн хэмжээ нь /ийн өрд зэлэх хувь/ дээд хязгаар 80.0 хувиас давсан байна. Засгийн газрын өрийн багцад хийсэн зардал, эрсдэлийн шинжилгээнд НЭДТГ-аас гаргасан дотоод, гадаад үнэт цаасны нэлөөллийг оруулж тооцоогүй байна.

Тайлбар: Монгол Улсын нэгдсэн төсөв 2023 онд 785.9 тэрбум төгрөгийн ашигтай, 2024 оны төсвийн тэнцэл төлөвлөснөөс 839.2 тэрбум төгрөгөөр бага алдагдалтай байсан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт оруулж Нэгдсэн төсвийн суурин тэнцлийн ашгаар Засгийн

газрын үндсэн төлбөрийг төлхөөр тусгасан зэрэг нь Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах шаардлагыг бууруулсан. Засгийн газраас 2024 онд хаалттай хэлбэрээр 300 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалсан бөгөөд 2025 оны төсвийг алдагдалгүй баталсантай холбоотойгоор нийт арилжаалах Засгийн газрын дотоод үнэт цаасны хэмжээ 300.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байхаар туссан болно.

Засгийн газрын зүгээс 2023-2024 онд 6.0 их наяд төгрөгийн үнэт дотоод цаас гаргасан тохиолдолд тус зорилтолт үзүүлэлтийг хангах байсан бөгөөд энэ нь хүүгийн зардал, Засгийн газрын өрийн үлдэгдлийг отгом нэмэгдүүлж, улсын төсөвт үр ашиггүй зардлыг үүсгэж, дарамт учруулах серег нэлеөтэй. Түүничлэн, Засгийн газрын гадаад зээлийн хувьд өмнө нь хэлэлцээрийг байгуулсан төслүүдийн зээлийн эх үүсвэрийг ашиглах, гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлж, дотоод эх үүсвэрээс боломжит хэмжээгээр төлж барагдуулах бодлогыг баримталж ажилласнаар Засгийн газрын өрийн багцын бусад зорилтот үзүүлэлтүүдийг хангаж ажилласан болно.

Тайлбар 5-ыг харна уу.

Тайлбар 6-г харна уу.

Тайлбар 7-г харна уу.

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Дугаар	Саналд өгөх тайлбар
Тайлбар 1	Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.
Тайлбар 2	Хэдийгээр хуулийн өөрчлөлтөөр аймаг, нийслэл бонд гаргаж төсөл, арга хэмжээ санхүүжүүлж болохоор байгаа ч стратегийн зорилт өөрчлөгдөөгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 3	Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.
Тайлбар 4	Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.
Тайлбар 5	Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.
Тайлбар 6	Стратеги хэрэгжиж байх хугацаанд Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулж, анх тооцсон төсөөлөлд дундаас нь нелөөлөхгүй байх талаар тайланд орууллаа.
Тайлбар 7	

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ аудитын дунд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, боломжит стратегиудыг тодорхойлсон байна. Харин эдгээр дундаас голлох стратегийг сонгосон үндэслэл тайлбарыг оруулаагүй, хэрэгжүүлэх арга замын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтгүй нь бодлогын хэрэгжилтийг үнэлэх, хянах нөхцөлийг бууруулж байна.
2. Өрийн удирдлагын зөвлөл 2023-2024 онд хуралдаагүй, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг боловсруулах үед төслийг, хэрэгжих хугацаанд явцыг дүгнэн зөвлөмж гаргаагүй нь Өрийн удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 -т заасан чиг үүрэгтэй нийцэхгүй байна.
3. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт өрийн удирдлагын дунд хугацаанд 6 бодлогын зорилтыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх 23 арга замыг тодорхойлсон ба хэрэгжилтийг Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу тайлагнасан байна.
4. Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд 41.8 болж буурсан нь Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл, бодит хүүгийн түвшин буурсан, дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт нэмэгдсэн, төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байсан зэрэг нь нөлөөлсөн ч уул уурхай, олборлолтын салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 23.0–28.1 хувийг эзэлж байгаа нь эдийн засаг нэг салбараас өндөр хамааралтайг харуулж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний төвлөрөл нь өрийн тогтвортой байдалд эрсдэл дагуулах хүчин зүйл болж болзошгүй байна.
5. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026–2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд Засгийн газрын өрийг дотоодын нийт бүтээгдэхүүний 45.0–55.0 хувьд барихаар тусгасан нь өрийн хязгаарыг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс хамаарч нэмэгдэх нөхцөлийг хязгаарласан зохицуулалт болсон ч уг хуульд байнга өөрчлөлт оруулж буй нь дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдол болон өрийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.
6. Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал 2023-2024 онд нийт 9,612.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 2,213.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Засгийн газраас 2025-2028 онд төлөх өрийн үйлчилгээний зардалд нийт 16,419.1 тэрбум төгрөг төлөхөөр байгаагаас үндсэн төлбөр 12,171.8 тэрбум төгрөг байгаа нь дахин санхүүжилтийн эрсдэл хэвээр байгааг, хүүгийн төлбөр 4,247.3 тэрбум төгрөг байгаа нь дунд хугацаанд төсөвт үргэлжлүүлэн ачаалал үзүүлэхээр байгааг тус тус харуулж байна.
7. Гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн хэмжээнд тооцогдох хүүгийн шимтгэлд 2023 онд 12.1, 2024 онд 39.4, нийт 51.5 тэрбум төгрөгийг тус тус төлсөн нь Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх, гэрээ хэлэлцээр байгуулахаас өмнөх төслийн бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байгааг харуулж байна.
8. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй байна.
9. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргасан бонд нь Өрийн удирдлагын тухай хуулийн зарчмуудыг хангаагүй ба богино хугацаатай, хүү өндөртэй арилжааны нөхцөлтэй зээллэгийн хөрөнгийг урт хугацаанд хэрэгжих дэд бүтцийн төсөл, арга хэмжээнд зарцуулж байгаа нь эдийн засгийн үр ашиггүй бөгөөд өмнөх бодлогын алдааг давтах эрсдэлтэй байна.

10. Засгийн газар өмнөх онуудад гаргасан гадаад үнэт цаасыг дахин үнэт цаас гаргах замаар санхүүжүүлэх, хугацаанаас өмнө буцаан худалдан авах зэрэг өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж, өрийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан байна. Хэдийгээр төсөвт хундрэл үүсгэхгүйгээр өрийг дахин санхүүжүүлж, Монгол Улс өрийн эрсдэлээс зайлсхийж чадсан эерэг нелөөтэй ч урт хугацаанд дахин санхүүжилтийн эрсдэл хэвээр байна.
11. Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 оны дунд үеэс буурч, өндөр эрсдэлтэй ангилалд байсан бол 2024 онд Фитч агентлагаас “B+, тогтвортой”, Эс энд Пи агентлагаас “B+, эерэг”, Мүүдис агентлагаас “B2, тогтвортой” төлөвтэй болгож ахиулсан байна.
12. Сангийн яам болон Үндэсний статистикийн хорооноос тархааж байгаа өрийн мэдээлэл зөрүүтэй байгаа нь Засгийн газрын өрийн үлдэгдэл аудитаар баталгаажиж Сангийн яамны тоон мэдээлэл эцэслэгдэх үед Үндэсний статистикийн хороо шинэчлэл хийдэггүй, мэдээллийг өөр бүтэцтэй гаргадаг зэрэгтэй холбоотой байна.
13. Сангийн яамнаас хийсэн Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргасан үнэт цаасны нөлөөллийг оруулалгүй, стратегийн зорилтуудын хүрээнд хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд өрийн багцын үзүүлэлтүүдээс 2023-2024 онд дахин санхүүжилтийн болон хүүгийн эрсдэл тодорхойлсон зорилтод түвшнээс хэтрээгүй ч ханшийн эрсдэл /гадаад валютаар илэрхийлсэн өрийн нийт өрд эзлэх хувь/-ийн зорилтод түвшин 80.0 хувьд хүрээгүй байна.
14. Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргасан үнэт цаасны нөлөөллийг оруулж тооцвол гол үзүүлэлтүүдийн 2024 оны зорилтот түвшнийг давж байна. Өрийн удирдлагын стратеги хэрэгжих байх үед Засгийн газрын өрийн багцын зардал эрсдэлийн шинжилгээний үр дүнгийн нөлөөллийг тооцохгүйгээр Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа нь Засгийн газрын өрийн бодит эрсдэлийг нэмэгдүүлж байна

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илэрсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа нь төсвийн тогтвортой байдал, өрийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг бууруулж байгаад анхаарлаа хандуулна уу.
- Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа Улсын Их Хурлаас баталж буй дунд хугацааны өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй уялдуулахгүй байгаа нь Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн төсөөлөл хангагдахгүй байх, хууль тогтоомжийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэл үүсэж байгаад анхаарлаа хандуулна уу.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийн, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

Тэргүүн шадар сайдв бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

- Гадаад зээлээр санхүүжигдэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх дараалал ач холбогдоор нь эрэмбэлж, өрийн удирдлагатай нийцүүлэн боловсруулж, ашиглаагүй зээлийн хүүгээс үргүй зардал төлөх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавих;

Сангийн сайдад:

- Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичигт хэрэгжүүлэх боломжит стратегиудаас голлох стратегийг, үндэслэлийн хамт тусган, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох;
- Хэрэгжүүлэхэд бэлэн болоогүй төсөл, арга хэмжээг сонгож зээлийн хэлэлцээрийг хийхгүй байх, богино хугацаатай, өндөр хүйтэй арилжааны нөхцөлтэй зээлийг урт хугацааны дэд бүтцийн төслүүдэд ашиглахаас зайлсхийх, зээлийн эх үүсвэрийг төслийн төлөвлөлттэй уялдуулж, зохистой санхүүжилтийн стратегийг боловсруулах;
- Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээнд аймаг, нийслэлийн үнэт цаасны нөлөөллийг тусгах, шинээр боловсруулагдах стратегийн баримт бичигт аймаг, нийслэлээс гаргах зээллэгийг төсөвт төвлөрүүлэх орлоготой уялдуулж, хязгаар тавьж егөх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг тогтвортой хөгжүүлэх, зах зээлийн дэд бүтцийг сайжруулан, тогтмол арилжаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;
- Засгийн газрын өрийн мэдээллийн эцэслэсэн тоон мэдээллийг тухай бүр Үндэсний статистикийн хороонд хүргүүлж, статистикийн мэдээллийн нэгдсэн санд тухайн мэдээллийг шинэчилж, нийцүүлэх ажлыг хамтран зохион байгуулах;

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид:

- Олон Улсын зах зээлд гаргасан гадаад бонд болон дотоодод гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээг үр дүнтэй хугацаанд нь хэрэгжүүлж, өрийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж, тэр дундаа эрсдэлийн удирдлагын чадавхыг сайжруулж, эргэн төлөлтийн эрсдэлээс сэргийлж ажиллах.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт, хэрэгжүүлэх арга замын хэрэгжилт

Зорилтууд	Дугаар	Хэрэгжүүлэх арга замууд	Хэрэгжсэн эсэх
Зорилт 1:Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслийдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.	1.1	Эдийн засгийн бодит ёсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг ёсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх <u>үүсвэрийг</u> авч ашиглахаас татгалзах;	Тийм
	1.2	Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;	Тийм, төсөл арга хэмжээг эрэмбэлэх чиг үүрэг хангалтгүй байна.
	1.3	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг хийхгүй байх.	Тийм
	2.1	Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, Засгийн газрын гадаад үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлэх;	Тийм
Зорилт 2:Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.	2.2	Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримталаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тийм
	2.3	Дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх;	Тийм
	2.4	Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах.	Тийм
	3.1	Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанктай хамтран ажиллаж, гадаад өрийн үйлчилгээний хуваарийг валютын нөөцтэй уялдуулах, шаардлагатай тохиолдолд валют болон хүүгийн своп хэлэлцээрийг зээлдүүлэгч талтай хийх;	Тийм
Зорилт 3:Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.	3.2	Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын ёсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн ёсeltееес хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү ёсөх тохиолдолд тогтмол хүйтэй зээл авах нөхцлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах;	Тийм
	3.3	Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсөл, арга хэмжээг дэмжиж, тэдгээрийн санхүүжилтийг Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн өрийн хэрэгсэлтэй уялдуулж, Засгийн газрын өрийн зохицуулалтын арга хэмжээнд нэвтрүүлэх боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангуулахад холбогдох яамтай хамтран ажиллах, түүнчлэн эдгээр арга хэмжээний ач холбогдлыг олон нийтэд таниулах;	Тийм

3.4	Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх нөхцөлийг бурдуулэх;	Тийм	
3.5	Орон нутгийн засаг захирагааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах.	Үгүй	
4.1	Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэг технологийг ашигласан систем нэвтрүүлэх;	Тийм	
4.2	Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч арилжаанд оролцсоноор бий болох үр ашиг, эрсдэлийн талаар иргэн, аж ахуйн нэгжийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх;	Үгүй	
Зорилт 4:Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.	4.3	Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрөвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах, зорилтот зах зээлд чиглэсэн Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулах дэд бүтэц болон хууль, эрх зүйн орчныг бурдуулэх;	Үгүй
	4.4	Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжаа зохион байгуулахадааас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулах.	Үгүй
Зорилт 5:Улсын стратегийн томоохон төслийдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.	5.1	Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслийдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;	Тийм
	5.2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсж болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайллагнах механизмыг бурдуулэх;	Тийм
	5.3	Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслийдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;	Тийм
	5.4	Төсвөөс шууд төлөгдхөн нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх;	Тийм
	5.5	Олон улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож байгаа болзошгүй эрсдэлээс сэргийлэх зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлэх.	Тайллагаагүй

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

Зорилт 6: Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.	6.1	Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх;	Тийм, мэдээллийн чанарыг сайжруулах шаардлагатай.
	6.2	Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх.	Тийм

Эх сурвалж: Аудитын тооцоолол

Хавсралт 2. Өрийн удирдлагын тухай хуулийн 14.3 дахь заалт, Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги боловсруулах удирдамж, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 ны стратегийн баримт бичгийн агуулгын харьцуулалт

Өрийн удирдлагын тухай хуульд тусгасан	Дунд хугацааны өрийн удирдлагын баримт бичиг боловсруулах удирдамжид аргачлалд тодорхойлсон	2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгасан
14.3.Стратегийн баримт бичигт дараах зүйлийг тусгана: 14.3.1.улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн тухайн үеийн нехцөл байдал; 14.3.2.Засгийн газрын өрийн шалгуур үзүүлэлтийн дунд хугацааны төсөөлөл; 14.3.3.санхүүжилтийн боломжит эх үүсвэр; 14.3.4.Засгийн газрын өрийн багцад дунд хугацаанд нөлөөлөх хүчин зүйлс; 14.3.5.Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн таамаглал; 14.3.6.Засгийн газрын өрийн баталгааны багцын тухайн үеийн нехцөл байдал, өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн таамаглал; 14.3.7.Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтэц; 14.3.8.өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга зам, өрийн зохицуулалтын үйл ажиллагаа; 14.3.9.бусад.	1. Өрийн удирдлагын зорилго, хамрах хүрээ 2. Засгийн газрын өрийн өнөөгийн нехцөл байдал 3. Санхүүжилтийн эх үүсвэрүүдийн шинжилгээ 4. Макро эдийн засгийн урьдчилсан төлөв 5. Боломжит стратегиудын үнэлгээ 6. Өрийн удирдлагын суурь стратеги 7. Стратегийн хэрэгжилт, хяналт •	1. Улсын нийт гадаад өр, засгийн газрын өрийн өнөөгийн нехцөл, байдал 2. Санхүүжилтийн боломжит эх үүсвэр 3.засгийн газрын өрийн баталгааны багцын өнөөгийн нехцөл байдал 4.Засгийн газрын өрийн шалгуур үзүүлэлтийн дунд хугацааны төсөөлөл ба нөлөөлөх хүчин зүйлс 5.Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлийн шинжилгээ 6.Дунд хугацаанд дэвшиүүлж байгаа зорилт, хэрэгжүүлэх арга зам 7.Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилт

Эх сурвалж: Аудитын тооцоолол

Хавсралт 3. Төсвийн хурээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал

д/д	Төсвийн жил	ТХМ баталсан огноо	ТХМ-д нэмэлт, өөрчлөлт оруулсан огноо	Жилийн төсвийг баталсан огноо /тодотгол/
1	2011	2010.07.07		2010.11.25 /2011.10.28/
2	2012	2011.07.09	2011.11.30	2011.11.30
3	2013	2012.05.22	2012.10.25	2012.11.08 /2013.10.25/
4	2014	2013.05.24	2013.11.14 2014.05.23	2013.11.15 /2014.05.23 2014.12.18/
5	2015	2014.05.30	2015.01.23 2015.10.30	2014.11.14 /2015.01.23 2015.10.30/
6	2016	2015.05.21	2015.11.13 2016.09.09	2015.11.13 /2016.09.09/
7	2017	2016.11.10	2017.04.14 2017.10.26	2016.11.10 /2017.04.14 2017.10.26/
8	2018	2017.05.31	2017.11.14	2017.11.14
9	2019	2018.05.25	2018.11.02	2018.11.02
10	2020	2019.05.30	2019.11.13 2020.08.28	2019.11.13 /2020.08.28/
11	2021	2020.08.28	2020.11.13 2021.07.07	2020.11.13 /2021.07.07/
12	2022	2021.05.06	2021.11.12 2022.01.31 2022.04.29	2021.11.12 /2022.01.31 2022.04.29/
13	2023	2022.05.27	2022.11.11 2023.06.15	2022.11.11 /2023.06.16/
14	2024	2023.05.31	2023.11.10 2024.08.30	2023.11.10 /2024.08.30/
15	2025	2024.06.05	2024.11.08 2024.12.12	2024.11.08 2024.12.12

Эх сурвалж: Аудитын тооцоолол

Хавсралт 4. Гадаад бондын үлдэгдэл, сая ам.доллар

Гадаад үнэт цаас	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Сенчири-2	-	-	-	-	-	-	650.0	650.0
Сенчири-2027	-	-	-	-	500.0	500.0	500.0	413.1
Сенчири-2031	-	-	-	-	500.0	500.0	500.0	500.0
Сенчири-3	-	-	-	-	-	-	350.0	350.0
Чингис-2017	127.2	-	-	-	-	-	-	-
Чингис-2022	1,000.0	1,000.0	1,000.0	799.2	136.8	-	-	-
Димсан	145.9	-	-	-	-	-	-	-
Гэрэгэ	800.0	800.0	800.0	800.0	533.1	517.2	-	-
Хуралдай	600.0	600.0	600.0	600.0	600.0	600.0	169.8	-
Мазаалай	500.0	500.0	500.0	132.6	-	-	-	-
Номад	-	-	-	600.0	600.0	600.0	578.0	566.0
Дүн	3,173.1	2,900.0	2,900.0	2,931.7	2,869.8	2,717.2	2,747.8	2,479.1